Хавсралт 1

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
## (2019 оны эхний хагас жилийн байдлаар тайлагнав)

*Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг – Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар*

2019-06-25 Улаанбаатар хот

| Шийд-вэрийн д/д | Заал-тын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар, заалт, агуулга | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал) | Тасарсан болон удааширч буй шалтгаан |
|---|---|---|---|---|---|
| **Нэг. УИХ-ын тогтоол** | | | | | |
| 1 | 1 | **Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай**<br>2016-11-03, № 51<br>2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан, холбогдон гарах зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Авлигатай тэмцэх газар /Х.Энхжаргал/-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан ТӨБЗГ-ын дангаар болон хамтран хэрэгжүүлэх 4 зорилтын хүрээний 17 арга хэмжээг хяналтад аван хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна. Эдгээр арга хэмжээний 2018 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн боловсруулж, 2019 оны А-1/671 дүгээр албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2018 оны жилийн эцсийн дүнгээр дунджаар 87.5 хувийн гүйцэтгэлтэй байна. ТӨБЗГ-ын 2018 оны төсөвт 157.8 сая төгрөгийг тусгаж батлуулснаас байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагаа, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор мэдээллийн самбарууд шинээр хийж байршуулан тогтмол ажиллуулах, цахим худалдан авах ажиллагааг хөгжүүлэх ажлын хүрээнд тендерийн үнэлгээг цахимаар хийх бэлтгэлийг хангаж зөөврийн компьютер, системийн сервер, хадгалах төхөөрөмжийг сайжруулахад 157.5 сая төгрөгийг зарцуулсан байна.<br>Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 2.5-д заасны дагуу үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусган | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжүүлж байна. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төлөвлөж, Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу байгууллагын 2020 оны төсвийн төсөлд тусгахаар холбогдох тооцоо судалгааг хийж байна. | | |
| 2 | 2 | **Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах, үргэлжлүүлэн хэрэгжүүлэх тухай**<br><br>2016-11-10, № 64<br><br>3.1. Төрийн өмчийг 2017-2018 онд хувьчлах үндсэн чиглэлийг Улсын Их Хурлаар батлах хүртэл төрийн өмчийг хувьчлах ажлыг Монгол Улсын Их Хурлын 2015 оны 70 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчийг 2015-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн дагуу үргэлжлүүлэн зохион байгуулахыг Монгол Улсын Засгийн газар /Ж.Эрдэнэбат/-т зөвшөөрсүгэй. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>ТӨБЗГ-аас 2018 онд “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 2018 оны 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Тус төслийг тухайн үед Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг Улсын Их Хуралд 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр өргөн барьсан. Улсын Их Хурлаас саналыг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасан. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан. | Хугацаа болоогүй – Үнэлэх боломжгүй. | ТӨБЗГ-аас хийвэл зохих шаардла-гатай ажлуудыг хийсэн. Тогтоолын төслийг эгүүлэн татсан нь ТӨБЗГ-аас хамаараа-гүй. Хасах саналтай. |
| | | **УИХ-ын тогтоол: 2 шийдвэрийн 2 заалт** | **70% - 1 заалт; ХБ/ҮБ – 1 заалт; Хэрэгжилтийн хувь - 70.0%.** | | |
| **Хоёр. Ерөнхийлөгчийн зарлиг** | | | | | |
| 3 | 3 | **Монгол баатарлаг туульсаа дээдлэн дэлгэрүүлэх тухай**<br><br>2019-01-29, № 13<br><br>3.Баатарлаг туульсаа дээдлэн хамгаалах, бүртгэн судлах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, олон улсад сурталчлан таниулах, туульч, өвлөн уламжлагч, өв тээгчид болон судлаачдыг урамшуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>Баатарлаг туульсаа дээдлэн хамгаалах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, олон улсад сурталчилан таниулах, туульч, өвлөн уламжлагч, өв тээгчид болон судлаачдыг урамшуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг нийт албан хаагчдад уриалж, Ерөнхийлөгчийн зарлигийг able.mn дотоод сүлжээнд байршуулан сурталчлан таниулсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 4 | 4.Монгол баатарлаг туульсынхаа агуулга, ач холбогдлыг таньж ойлгох, дэмжин дэлгэрүүлэх, өв соёлоо хүндэтгэн дээдлэх, хадгалах, уламжлуулан хамгаалах үйлсэд идэвх санаачлагтай оролцохыг төрийн ба төрийн бус байгууллага, иргэд олон нийт, эрдэмтэн судлаачид, шинжлэх ухааны ба хэвлэл мэдээллийн байгууллагуудад уриалсугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Баатарлаг туульсаа дээдлэн хамгаалах, өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, олон улсад сурталчилан таниулах, туульч, өвлөн уламжлагч, өв тээгчид болон судлаачдыг урамшуулах үйл ажиллагааг дэмжиж ажиллахыг нийт албан хаагчдад уриалж, Ерөнхийлөгчийн зарлигийг able.mn дотоод сүлжээнд байршуулан сурталчлан таниулсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | | **Ерөнхийлөгчийн зарлиг:**<br>**1 шийдвэрийн 2 заалт** | **100% - 2 заалт; Хэрэгжилтийн хувь - 100.0%.** | | |
| **Гурав. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж** | | | | | |
| 4 | 5 | **Мөнгө угаахтай тэмцэх зарим арга хэмжээний тухай**<br>2017-07-19, № 19/5<br>1.Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжүүдийг төрийн бүх шатны байгууллага үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт энэ чиглэлээр үүссэн гомдол, маргаан байхгүй бөгөөд олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжийг анхаарч, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.<br>ТӨБЗГ-аас зарлаж буй тендер шалгаруулалтад оролцогч компаниудад зөвхөн эрх бүхий арилжааны банкаар тендерийн баталгаа гаргуулах, авах боломжтой зээлийн тодорхойлолт ирүүлэхийг тендерийн баримт бичигт тусган ажиллаж байна. Эрүүгийн цагдаагийн газартай хамтран ажиллаж, тус газарт шалгагдаж буй эрүүгийн хэрэгт ТӨБЗГ-ын холбогдох худалдан авах ажиллагааны мэргэжилтнүүд шинжээчээр ажиллаж буй 2 тохиолдол байгаа болно.<br>Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн “Монголбанканд гадаад валют худалдах зарим арга хэмжээний тухай” 03/03/А5 дугаар хамтарсан тушаалаар Төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн үйл ажиллагааны явцад бий болсон гадаад валют-ам.долларыг Монголбанкны тухайн өдрийн зарласан ханшаар Монголбанканд худалдаж байх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгасан. Хамтарсан тушаалын хэрэгжилтийг хангуулахаар ТӨБЗГ-ын 2019 оны 01-р сарын 14-ний өдрийн “Тушаалын хэрэгжилтийг хангуулах тухай” А-1/89 дүгээр албан бичгийг нийт төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 94 хуулийн этгээдэд хүргүүлэв. Энэ талаарх тайлан мэдээллийг 2019 оны эхний 5 сарын байдлаар нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэв. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **ҮАБЗ-ийн зөвлөмж: 1 шийдвэрийн 1 заалт** | **100% - 1 заалт; Хэрэгжилтийн хувь – 100%.** | | |
| | | | **Дөрөв. Засгийн газрын тогтоол** | | |
| 5 | 6 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулах тухай**<br>2013-10-05, № 336<br>3.Монгол Улс ба Нордикийн хөгжлийн сан хооронд байгуулсан зээлийн хэлэлцээрийн хүрээнд олгосон зээлийн үлдэгдлийн тооцоог гаргаж баталгаажуулах, Автотээврийн үндэсний төвтэй дамжуулан зээлдүүлэх гэрээг шинэчлэн байгуулж зээлийн эргэн төлөлтийг тус төвийн жил бүрийн зорилтот түвшинд тусган барагдуулах арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Улаан, Зам, тээврийн сайд А.Гансүх нарт даалгасугай. | **ТӨБЗГ - БТУХ**<br>Санхүү, эдийн засгийн яам (хуучнаар) "Авто тээврийн газар"-ын хооронд 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан 122/11/55/ дугаар гэрээний хавсралт дахь дамжуулан зээлдүүлэхэд өөрчлөлт оруулан зээлийн төлбөрийн хуваарийг шинэчлэн, зээлийг төлж эхэлсэн. 2017 онд зээлийн үлдэгдлийг Сангийн яамны Өрийн удирдлагын хэлтэстэй тооцоо нийлэн баталгаажуулж, 2013 оноос хойш төлж эхэлсэн бөгөөд зээлийн эргэн төлөлт одоогийн байдлаар 59.3 хувийн гүйцэтгэлтэй байна.<br>Зээлийн эргэн төлөлтийг үйлдвэрийн газрын жил бүрийн зорилтот түвшинд тусгах арга хэмжээ авахыг даалгасны дагуу 2019 оны зорилтот түвшинд тусган хэрэгжилтийг хангах арга хэмжээ авсан. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| 6 | 7 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-12-21, № 193<br>2. Монгол Улсаас гадаад улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудын эзэмшилд байгаа Монгол Улсын төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг тухайн орны үнэлгээний жишигт нийцүүлэн үнэлүүлж санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулахыг Гадаад харилцааны сайд Ц.Мөнх-Оргил, Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Сангийн Сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу Монгол Улсаас гадаад улсад суугаа 23 Дипломат төлөөлөгчийн газруудын эзэмшилд байгаа Монгол Улсын төрийн өмчийн газар, үл хөдлөх хөрөнгийг тухайн орны үнэлгээний жишигт нийцүүлэн үнэлүүлж, санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулав. Үнэлгээний дүнг 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгуулсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| | 8 | **Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2016-12-21, № 193 | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Ажлын хэсгийн тайланг ХЗДХЯ-нд хүргүүлж саналаа өгсөн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг эд хөрөнгийн эрхийн бүртгэлд бүртгүүлэхээр хуульчилсан. Хууль 2018 оны 11 дүгээр сарын | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 5. Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх болон тухайн хөрөнгийг төрийн байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах эрхийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх асуудлыг судлан, тодорхой санал боловсруулж, 2017 оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. | | |
| 7 | 9 | **УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай**<br>2017-02-01, № 42<br>1. Улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлсэн зээлийн багцыг Хөгжлийн банкнаас Засгийн газарт шилжүүлэхтэй холбогдуулан төсөл санхүүжүүлэх зорилгоор Хөгжлийн банктай байгуулсан холбогдох зээлийн гэрээг дүгнэж эрх үүргийг шилжүүлэн авах, дуусгавар болгох, баримт бичгийг хэлээлцэх үүрэг бүхий Ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК-ийн зээлийн хөрөнгөтэй холбоотой асуудлыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хөгжлийн банкнаас байгуулагдсан Ажлын хэсэг хариуцан ажилласан болно. “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК-ийн гүйцэтгэх захиралтай холбоо тогтоох боломжгүйгээс шалтгаалан зээлийн гэрээ дүгнэсэн актад “Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК-ийг төлөөлөн гарын үсэг зурах бүхий этгээдийг томилох шаардлага үүссэн тул Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 438 дугаар тогтоолоор ажлын хэсгийн дүгнэлттэй танилцах, Хөгжлийн банктай байгуулсан зээлийн гэрээг дүгнэх, дүгнэсэн актад гарын үсэг зурах эрхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтсийн дарга Ц.Баяр-Эрдэнэд олгосон. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс зээлийн гэрээ, зээл төлөлтийн талаар мэдээлэлтэй урьдчилан танилцаад гэрээ дүгнэсэн акт бэлэн болмогц гарын үсэг зурах тухай мэдэгдсэн.<br>Хөгжлийн банкны зүгээс гэрээ дүгнэсэн актыг бэлтгэн ирүүлээгүй байгаа тул гэрээг дүгнэж, гарын үсэг зурах ажил ТӨБЗГ-аас хамаарахгүйгээр хойшлогдсон. | “Хэрэгжилт хангалтгүй” – 30% | ТӨБЗГ-аас хамаарах-гүйгээр удааширч байгаа. |
| | 10 | **УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай**<br>2017-02-01, № 42<br>2. Ажлын хэсгийн тайлан, үр дүнг 2017 оны 2 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг төслийн ерөнхийлөн захирагч нар болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зүгээс гэрээ дүгнэсэн актад гарын үсэг зурахад бэлэн тухайгаа мэдэгдсэн бөгөөд Хөгжлийн банкнаас гэрээ дүгнэсэн актыг бэлтгэн ирүүлээгүй байгаа болно.<br>**Тэмдэгдэл: ЗГХЭГ-аас 2018 оны жилийн эцсийн үнэлгээгээр энэ заалтын хэрэгжилтийг холбогдох журмын дагуу “0” гэж үнэлэхийг шаардсан. Засгийн газрын 2018 оны үнэлгээгээр “0” үнэлэгдсэн байна.** | “Хэрэгжилт хангалтгүй” – 30% | ТӨБЗГ-аас хамаарах-гүйгээр удааширч байгаа. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | | | |
| 8 | 11 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2017-08-09, № 219<br>1. Төрийн банкны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 377,017,720.00 (гурван зуун далан долоон сая арван долоон мянга долоон зуун хорин) төгрөгийн балансын үнэтэй, 82,399,633.13 (наян хоёр сая гурван зуун ерэн есөн мянга зургаан зуун гучин гурван төгрөг арван гурван мөнгө) төгрөгийн элэгдэл бүхий хавсралтад заасан дөрвөн барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>2 удаа дуудлагын худалдааг зарлаад оролцогч ирээгүй тул худалдах доод үнийг 50 хувь буулгаж дахин зарласан. 2018 оны 7 дугаар сарын 16-нд дуудлагын худалдааг зохион байгуулж, Архангай аймгийн Эрдэнэбулган суманд байрлах Төрийн банкны тооцооны төвийн барилга нь 133,450,000 төгрөгөөр зарагдсан. ТӨБЗГ-ын 2018 оны 10 сарын 16-ны өдрийн хуралдаанаар асуудлыг оруулж хэлэлцүүлэн 439 дүгээр тогтоолоор Өмчлөх эрхийг шилжүүлсэн.<br>Төрийн банкнаас зарагдаагүй 3 барилгыг худалдахгүй байхаар шийдвэрлэж, хүсэлтээ ирүүлсэн болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 12 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2017-08-09, № 219<br>2. Дуудлагын худалдааны орлогыг улсын төсөвт төвлөрүүлэхийг Сангийн сайд Б.Чойжилсүрэн, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Төрийн банкны гүйцэтгэх захирал Б.Цэндсүрэн нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Архангай аймгийн Эрдэнэбулган суманд байрлах Төрийн банкны тооцооны төвийн барилгыг худалдан борлуулсны орлого 133,450,000 төгрөгийг Төрийн сан банкин дахь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын данс 100900000721 дугаар дансанд төвлөрүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| 9 | 13 | **Хувьцааны хөрөнгө шийдвэрлэх тухай**<br>2017-10-25, № 300<br>3. “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн менежментийг сайжруулан үйл ажиллагааг нь дэмжиж, үр ашигтай ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжилтэд нь хяналт тавьж | **ТӨБЗГ – БТУХ**<br>Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2018 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар “Монголын цахилгаан холбоо” ХК-ийн менежментийг сайжруулан үйл ажиллагааг нь дэмжиж, үр ашигтай ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авч, хэрэгжилтэд нь хяналт тавих үүрэг бүхий Сангийн яам, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулсан. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор), Харилцаа холбооны зохицуулах хороо (С.Адъяасүрэн), Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Чинбатад үүрэг болгосугай. | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2018 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 1/778 дугаар албан бичгийг “Монголын цахилгаан холбоо” ХК-д хүргүүлж, нийт 5 зөвлөмжийг авч хэрэгжүүлэн 2018 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг үүрэг болгосон. Тус зөвлөмжийн дагуу компани төрийн өмчийн болон төрийн байгууллагуудад үйлчилгээ хүргэх, өргөжүүлэх чиглэлээр багцын үйлчилгээ нэвтрүүлэх, өргөн зурвасын утасгүй суурин интернэтийн сүлжээ байгуулах (LTE), үйлчилгээ эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл авах, “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХХК-тай байгуулсан холбогдох гэрээнүүдийг шинэчлэх, ашиглалтыг сайжруулах, компанийн 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд ОТТ үйлчилгээ нэвтрүүлэх төслийг тусган хэрэгжилтийг хангах ажлуудыг гүйцэтгэж байна. Мөн Засгийн газрын 2019 оны 149 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэхээр “Монголын цахилгаан холбоо” ХК нь 28 суманд төрийн үйлчилгээг операторын горимоор ажиллуулах төлөвлөгөө гарган ажиллаж байна. | | |
| 10 | 14 | **“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**<br>2017-11-29, № 322<br>3. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийг японы талтай хамтран байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийг японы талтай хамтран байгуулах асуудлын хүрээнд Ерөнхий сайдын захирамжаар томилогдсон ажлын хэсэг ажиллаж байна.<br>Японы талын консерциум болон “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ХХК-ийн хооронд түншлэлийн гэрээг байгуулсан. Японы тал хамтарсан компанийн 51 хувийг эзэмших хуулийн этгээд болох “Жапан эйрпорт менежмент” ХХК-ийг байгуулсан.<br>Ажлын хэсэг хувьцаа эзэмшигчийн гэрээний төслийг Японы талтай хэлэлцэн эцэслэн боловсруулсан. “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК, “Жапан эйрпорт менежмент” ХХК ажлын хэсгийн бэлэн болгосон хувьцаа эзэмшигчийн гэрээний төслийг нягтлах, тодорхой болгох талаар хамтран ажиллаж, 2019 оны 6 дугаар сард багтаан хамтарсан компани байгуулахаар бэлтгэл хангаж ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 15 | **“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай**<br>2017-11-29, № 322<br>4. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээдтэй хэлэлцээ хийж, | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсэг Ерөнхий сайдын захирамжаар томилогдон Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулан ажилласан. ТӨБЗГ-ын төлөөлөл уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллав. Концессын гэрээг байгуулах асуудлыг | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | холбогдох гэрээний төслийг 2017 оны 12 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Үндэсний хөгжлийн газар (Б.Баярсайхан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанд танилцуулсан бөгөөд уг асуудалтай холбоотойгоор Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гарсан.<br><br>“Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийн концессын гэрээг Японы талаас хэрэгжүүлэх санал тавьсан "Консорциум SPV" буюу “Жапан Эйрпорт Менежмент” ХХК болон Монгол талын “Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал” ТӨХХК-тай хамтарсан Тусгай зориулалтын компанитай байгуулах нь зүйтэй гэж ажлын хэсэг дүгнэсэн.<br><br>Ажлын хэсгийн зүгээс Хөрөнгө Оруулах-Ашиглах-Шилжүүлэх (Iot) төрлийн концессын гэрээний төслийг бэлэн болгож, Үндэсний хөгжлийн газарт хүлээлгэн өгөөд байна. | | |
| 11 | 16 | **“Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг нээлттэй хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, нийт хувьцааны тодорхой хэсгийг иргэдэд эзэмшүүлэх тухай**<br><br>2018-01-10, № 10<br><br>1.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн зохион байгуулах, нийт хувьцааны тодорхой хувийг Монгол Улсын нийт иргэдэд эзэмшүүлэх асуудлыг боловсруулан Засгийн газарт оруулж хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Д.Сумъяабазар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Засгийн газрын 2019 оны 91 дүгээр тогтоол гарч, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д онцгой дэглэм тогтоосон, УИХ-ын 23 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын 102 дугаар тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийг төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулсан бөгөөд Онцгой дэглэмийн үед энэхүү тогтоол хэрэгжих боломжгүй. | Хугацаа болоогүй – Үнэлэх боломжгүй. | ТӨҮГ болгох Засгийн газрын шийдвэр гарсан тул хяналтаас хасуулах саналтай байна. |
| 12 | 17 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай**<br><br>2018-01-10, № 8<br><br>1.“Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>ТӨБЗГ-аас 2018 онд “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 2018 оны 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Тус төслийг тухайн үед Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 | Хугацаа болоогүй – Үнэлэх боломжгүй. | ТӨБЗГ-аас хийвэл зохих шаардла-гатай ажлуудыг |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Улсын Их Хурлын тогтоолын төслийг дараах зарчмыг баримтлан Засгийн газрын гишүүд болон Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын саналыг авсны үндсэн дээр боловсруулж, 2018 оны I улиралд багтаан танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Нямосор)-т даалгасугай:<br><br>1.1. олон нийтийн оролцоог хангах, хяналтын тогтолцоог төлөвшүүлэх, компанийн засаглалыг сайжруулах, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, техник, технологийг шинэчлэх, хөрөнгө оруулалт татах зорилгоор төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцааг үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгүүлэх, төрийн мэдлийн хувьцааны тодорхой хувийг хөрөнгийн биржээр арилжаалах;<br><br>1.2. хувийн хэвшилд суурилсан зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих бодлого баримталж, үйлдвэрлэл, үйлчилгээний салбар дахь төрийн оролцоог бууруулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн өмчит зарим хуулийн этгээдийг хөрөнгийн биржээр болон нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчлах. | хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг Улсын Их Хуралд 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр өргөн барьсан. Улсын Их Хурлаас саналыг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасан. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан. | | хийсэн. Тогтоолын төслийг эгүүлэн татсан нь ТӨБЗГ-аас хамаараагүй. Хасах саналтай. |
| | 18 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай**<br><br>2018-01-10, № 8<br><br>2. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компаниудын үр ашгийг дээшлүүлэх талаар дараах арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлэхийг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>2.1.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн засаглалын өнөөгийн түвшинг тогтоох, цаашид засаглалыг сайжруулах чиглэл, удирдлага, хяналтын тогтолцоог зохистой болгох, үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагыг чадавхжуулах чиглэлээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Азийн сан, “Компанийн засаглалын хөгжлийн төв” ТББ хамтран ажиллах төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулсан байдалд аудит хийн, | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тус даалгасугай: 2.1.компанийн засаглалыг сайжруулж, ил тод, нээлттэй байдлыг хангах, үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тогтолцоог бий болгох; 2.2.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх; 2.3.удирдлага, менежментийг сайжруулах, үргүй зардлыг багасгах зорилгоор төрийн өмчит зарим хуулийн этгээдийг нэгтгэх, татан буулгах, өөрчлөн зохион байгуулах; 2.4. төрийн өмчийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, ажил дүгнэх шалгуур үзүүлэлт, түүнийг дүгнэх аргачлалыг шинэчлэн боловсруулж, батлан мөрдүүлэх; 2.5.компанийн удирдлага, ажиллагсдын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, төрд төлсөн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлал гаргаж мөрдүүлэх; 2.6.өр, авлага болон дамжуулан зээлдүүлэх гэрээний хүүг бууруулах талаар тодорхой арга хэмжээг үе шаттайгаар авах; 2.7.төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулж, дотоодын үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээг тэргүүн ээлжинд авах боломжийг бүрдүүлж, | шилэн дансны цэсээ тогтмол шинэчлэн мэдээллийг олон нийтэд хүргэн ажиллах талаар албан бичиг хүргүүлж, чиглэл өгөн хэрэгжилтэд хяналт тавьж байна.<br><br>2.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-1/350 дугаар албан бичгээр “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс дээд шатны байгууллага, төрийн захиргааны байгууллагын зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох, зөрчсөн албан тушаалтанд хуулийн хүрээнд арга хэмжээ авч байх” талаар албан даалгавар хүргүүлсэн. Албан даалгаврын биелэлтийг нэгтгэн, хяналт тавьж, үр дүнг гүйцэтгах удирдлагын контрактыг дүгнэхэд харгалзаж байгаа болно.<br><br>2.3.Төрийн өмчит зарим хуулийн этгээдийн удирдлага, менежментийг сайжруулах, үргүй зардлыг багасгах зорилгоор төрийн өмчит зарим хуулийн этгээдийг нэгтгэх, татан буулгах, өөрчлөн зохион байгуулах саналыг Засгийн газарт хүргүүлж, Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай” 9 дүгээр тогтоолыг батлуулан татан буулгах комиссууд ажиллаж байна. Татан буулгах комиссын ажил эцэслэн дуусаагүй байна.<br><br>2.4."Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг шинэчлэн боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлуулсан. Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс гүйцэтгэх захиралтай байгуулах контрактын загвар, төрийн өмчит үйлдвэрийн газрын захиралтай байгуулах контрактын загварт өөрчлөлт оруулсан.<br><br>2.5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-д компанийн удирдлага, ажиллагсдын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, төрд төлсөн ногдол ашигт тулгуурлан тооцох асуудлыг тусгасан.<br><br>2.6.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн авлага, өглөгийг бууруулах талаар албан даалгавар хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ аван ажиллаж байна.<br><br>2.7.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар нь төрийн худалдан | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах. | авах ажиллагааны цахим систем https://tender.gov.mn –ийг хариуцан ажиллаж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг нээлттэй, ил тод болгох ажлыг зохион байгуулан хяналт тавин ажиллаж байна. | | |
| | 19 | **Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар авах арга хэмжээний тухай**<br><br>2018-01-10, № 8<br><br>3. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг дүгнэж, цаашид уг асуудлаар өөрчлөлт, шинэчлэл хийх, хувьчлах байгууллагын талаар санал боловсруулахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ц.Цогзолмаа, Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг нарт, эдгээр саналыг нэгтгэх замаар 2018-2020 онд нийгмийн салбарын өөрчлөлт, шинэчлэл хийх, хувьчлах байгууллагын жагсаалт гарган танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>“Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, цаашид тус салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх саналыг боловсруулан Засгийн газарт танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг Ерөнхий сайдын 2018 оны 66 дугаар захирамжаар байгуулагдсан. Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл”, Засгийн газрын 2003 оны 34 дүгээр тогтоолын хэрэгжилт, биелэлтийг ТӨБЗГ-аас Ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн болно. Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж, гарах шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах болно. | “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – Үнэлэх боломжгүй. | |
| 13 | 20 | **Төрийн өмчит зарим хуулийн этгээдийг татан буулгах тухай**<br><br>2018-01-10, № 9<br><br>2. Хавсралтад заасан төрийн өмчит хуулийн этгээдийг татан буулгах ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай нь хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, дүнг Засгийн газарт танилцуулж гүйцэтгэлийг тайлагнахыг Сангийн сайд | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар татан буулгах 4 комисс байгуулагдан хууль тогтоомжийн дагуу ажиллаж байна:<br><br>“Монгол тамга” ТӨҮГ-ыг Татан буулгах комисс тус үйлдвэрийн газрын захирлаар ажиллаж байсан Д.Рэнцэнтавхайтай холбоотой авлагын асуудлыг Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд хүргүүлж, “Засгийн газрын байруудын нийтлэг үйлчилгээний газар” ТӨҮГ-аас “Монгол тамга” ТӨҮГ-ын эд хөрөнгө хадгалагдаж байсан өрөөг чөлөөлөх, эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдах, өр, | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | авлагыг бууруулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Мөн Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 07 сарын 18 өдрийн 101/ШШ2018/02423 дугаар шийдвэрээр нийт 16,632,061.96 (Арван зургаан сая зургаан зуун гучин хоёр мянга жаран нэгэн төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийг ХХААХҮЯ-наас гаргуулан “Монгол тамга” ТӨҮГ-т олгуулахаар шийдвэрлэсэн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахаар Татан буулгах комиссын 2019 оны 50 тоот албан бичгийг тус яаманд хүргүүлсэн. Шийдвэр хэрэгжээгүй байна.<br><br>“Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийг татан буулгах үүрэг бүхий Ажлын хэсэг нийт 8 удаа хуралдаж, 32 албан бичиг, 8 тогтоол, 1 тэмдэглэл, 8 дэлгэрэнгүй тэмдэглэл гаргаад байна. Тус Ажлын хэсгээс 6.9 сая төгрөгийн авлага, 206.5 сая төгрөгийн өглөгийг барагдуулсан. Мөн Үндэсний архивын газарт компанийн архивын бичиг баримтыг хүлээлгэн өгсөн. Татан буугдсан уг компанийн санхүүгийн хаалтын тайлан тэнцэл, хөрөнгийн хөдлөл, өр авлагын барагдуулалтын талаарх дүнг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. “Авто замын тоног төхөөрөмжийн түрээс” ТӨХК-ийн хувь хүн болон улсын төсөвт төлөх өглөг, конторын болон гражийн барилгыг “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-т балансын дүнгээр шилжүүлсэн. Татан буулгах комиссын ажил дууссан.<br><br>“Аж үйлдвэрийн цогцолбор” ТӨХК-ийн татан буулгах комисс иргэд, аж ахуйн нэгжүүдээс тогтоосон хугацаанд өргөдлийг хүлээн авах, өр төлбөрийн мэдээллийг нэгтгэх, “БООБШ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн удирдлага, ажилтнуудаас компанийн эд хөрөнгийг жагсаалтаар хүлээн авч акт үйлдэх зэрэг ажлуудыг хийв.<br><br>“Монгол тариалан корпораци” ТӨҮГ, “Монгол мах корпораци” ТӨҮГ-тай өр, авлагын тооцоотой хувь хүн, хуулийн этгээдтэй тооцоо нийлэх, баталгаажуулалт хийх ажлыг зарлан зохион байгуулав. Зарласан хугацаанд ямар нэгэн хүсэлт, гомдол ирээгүй байна. | | |
| 14 | 21 | **2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай**<br><br>2018-01-31, № 32<br><br>2.1.“Хариуцлагын жил”-ийн хүрээнд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дор дурдсан арга хэмжээг тусгай төлөвлөгөө гарган зохион байгуулж тайланг хууль тогтоомжид заасан хугацаанд Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, | **ТӨБЗГ - ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн 2018 оны жилийн эцсийн тайланг гаргаж, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, агентлагийн Даргын Зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хамтаар 2019 оны А-1/247, А-1/174 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай: Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан төсөл, арга хэмжээг хугацаанд нь зохион байгуулан дүгнэж ажиллах; | Сангийн яаманд тус тус хүргүүлэв.<br><br>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ТӨБЗГ-т хамаарал бүхий нийт 22 арга хэмжээний хэрэгжилт 2018 оны жилийн эцсийн дүнгээр 90.0 хувийн үнэлгээтэй дүгнэгдэв. 2019 оны зорилтот түвшингийн эхний хагас жилийн тайлан эцэслэн гараагүй байна.<br><br>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд ТӨБЗГ-т хамаарал бүхий 4 зорилт, арга хэмжээ тусгагдсан бөгөөд түүний хэрэгжилт жилийн эцсийн дүнгээр 100.0 хувийн үнэлгээтэй байна. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд ТӨБЗГ-ын дангаар буюу хамтран хэрэгжүүлэх 2 зорилт, арга хэмжээ тусгагдсан бөгөөд 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилт 100.0 хувийн үнэлгээ бүхий дүнтэй байна. Эхний хагас жилийн тайланг ТӨБЗГ-ыан А-2/1826 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэв. | | |
| | 22 | **2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай**<br><br>2018-01-31, № 32<br><br>2.2. яам, Засгийн газрын агентлаг, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллага бүр хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэлбэрэлтгүй биелүүлж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг нэг цэгээс шуурхай өгч, төрийн үйлчилгээг хүнд суртал, чирэгдэлгүй зохион байгуулж, ахиц дэвшил гаргах арга хэмжээ авах; | **ТӨБЗГ - ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-өөр дамжуулан 2019 оны эхний хагас жилд төрийн худалдан авах ажиллагааны цахим системтэй холбоотой 3, худалдан авах ажиллагаатай холбоотой 1, орон сууц хувьчлалтай холбоотой 1, газрын цахим хуудастай холбоотой 1, нийт 6 иргэн санал, хүсэлт, гомдол, ирүүлснийг хүлээн авч, бүртгэлд хамруулан хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллав.<br><br>2019 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 102 өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авч, байгууллагын дотоод сүлжээ www.able цахим системд бүртгэн, удирдлагын заалтын дагуу албан хаагчид хуваарилан хүргүүлснээс шийдвэрлэгдсэн 86, хяналтад 10, хугацаа хэтэрсэн, шийдвэрлэгдээгүй 5 (ЗХЗХ-1, БТУХ-3, ТӨБХХ-1) өргөдөл байна. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд 2018 оны жилийн эцэс, 2019 оны 1 дүгээр улирлын шийдвэрлэлтийн тайланг газрын цахим хуудсанд байршуулсан.<br><br>Мөн 2019 оны 4 дүгээр сард “Албан бичиг, өргөдөл гомдлын хугацаа хэтрэлтэд дотоод аудит хийх” тухай удирдамжийг ТӨБЗГ-ын даргаар батлуулан 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацааг хамруулан аудит хийж, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | зөвлөл болон нийт албан хаагчдад танилцуулж, холбогдох хууль, журам зааврын мөрдөлтийг сайжруулж, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар" өөрчлөлт оруулах зөвлөмж өгсөний дагуу хэрэгжилтийг хانган ажиллаж байна. | | |
| | 23 | **2018 оныг "Хариуцлагын жил" болгон зарлах тухай**<br>2018-01-31, № 32<br>2.3. төрийн захиргааны бүх шатны байгууллага ажиллагсадтайгаа байгуулсан үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцон ажиллаж байх; | **ТӨБЗГ - ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө жилээр болон улирлаар төлөвлөж сар бүр тайлагнаж байхаар зохицуулагдсаны дагуу албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2019 оны 2 дугаар улирлын биелэлтийг тайлагнах ажил хийгдэж байна. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| 15 | 24 | **Орон сууц хувьчлах тухай**<br>2018-03-27, № 78<br>2. Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн тогтоолоор Булган аймгийн орон сууц хувьчлах товчоог байгуулах шийдвэр гаргасан. Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор орон сууц өмчлөх эрхийг шилжүүлэн олгуулахаар Нийслэлийн Орон сууц хувьчлах товчоонд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны А-1/1330, Булган аймгийн Орон сууц хувьчлах товчоонд 2018 оны А-1/1230 дугаар албан бичгийг тус тус хүргүүлж, орон сууц эзэмшигчдэд өмчлөх эрхийг шилжүүлэн олгох ажлыг зохион байгуулсан болно. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| 16 | 25 | **"Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай**<br>2018-03-27, № 81<br>1. "Түрээсийн орон сууц" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор "Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй хавсралтад заасан орон сууцны дуусаагүй барилгыг хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрт нь тооцон Хөгжлийн банкинд шилжүүлэх арга хэмжээ авахыг | **ТӨБЗГ – БТУХ**<br>Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төсөл тус бүрээр гүйцэтгэгч компаниудтай санхүүжилтийн тооцоо нийлж, баталгаажуулсан.<br>"Төрийн орон сууцны корпораци" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад бүртгэлтэй 1562 айлын орон сууцны дуусаагүй барилгын гүйцэтгэлийн санхүүжилтээр зээл, зээлийн хүүгийн зардал болон бусад зардлыг тооцон нийт 46,480,617,835.77 (дөчин зургаан тэрбум дөрвөн зуун наян сая зургаан зуун арван долоон мянга найман зуун гучин таван төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн зардлыг өртөгт тооцон дуусаагүй барилгыг шилжүүлэхээр Хөгжлийн банкинд саналаа | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт тус тус даалгасугай. | хүргүүлсэн.<br>Монгол Улсын Хөгжлийн банк, Барилга, хот байгуулалтын яам, "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ-ын хооронд 2018 оны 05 дугаар сарын 18-ны өдөр гэрээ байгуулан ажиллаж, 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн "Төрийн орон сууцны корпораци" ТӨҮГ болон Монгол Улсын Хөгжлийн банк хооронд тооцоо нийлсэн №3/94 дугаар тай актаар баталгаажуулан нийт 35,477,278,511.51 төгрөгийн үнийн дүн бүхий барилгыг шилжүүлсэн. Энэхүү дүнд зээлийн хүү, барилгын ажлын чанарын баталгаа, захиалагчийн хяналтын зардал, барилгын зураг төслийн үнэ зэрэг бодит зардлуудыг орхигдуулсан байсан.<br>Орхигдуулсан зардлууд болох зээлийн хүү, барилгын ажлын чанарын баталгаа, захиалагчийн хяналтын зардал, барилгын зураг төслийн үнэ зэрэг бодит зардлуудыг талууд хэлэлцсэний үндсэн дээр 10,722,066,111 төгрөгөөр нэмэгдүүлж, 46,199,344,623 төгрөгийн үнэ бүхий дуусаагүй барилгыг Монгол Улсын Хөгжлийн банкинд шилжүүлэх талаар Монгол Улсын Хөгжлийн банк, Барилга хот байгуулалтын яам, Төрийн орон сууцны корпорацийн төлөөлөл гарын үсэг зурж, 3/94А дугаартай нэмэлт актаар баталгаажуулан Монгол Улсын Хөгжлийн банкинд шилжүүлсэн. | | |
| 17 | 26 | **Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**<br>2018-04-25, № 111<br>5. Жендэрийн үндэсний хорооны ажлын албыг Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд ажиллуулах болж байгаатай холбогдуулан байр, эд хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Жендэрийн үндэсний хорооны Ажлын албыг "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ-ын 13 дугаар байранд байрлуулах талаар Ерөнхий сайдын Ажлын албаны даргын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн Х/1024 дугаартай албан бичиг, Гадаад харилцааны сайдын 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 08/70 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус харгалзан судалж шийдвэрлэв. "Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар" ТӨҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 412 м.кв талбай бүхий 13 дугаар байрыг бүхэлд нь Жендэрийн үндэсний хорооны Ажлын албанд түрээслүүлэхээр Төрийн өөрийн өмчийн түрээсийн ТӨ-2019/003 дугаартай гэрээг 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар байгуулж баталгаажуулсан. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| 18 | 27 | **Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2018-08-01, № 232<br>2. "Нарийнсухайтын төмөр зам" ХХК-тай хамтарсан төрийн өмчийн тавин нэгээс | **ТӨБЗГ – БТУХ**<br>Тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ТӨБЗГ-аас 2018 онд өгсөн зөвлөмж, чиглэлийн дагуу "Монголын төмөр зам" ТӨХК нь "Шивээхүрэн төмөр зам" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн гэрээний гол нөхцөлүүд, гэрээний төслийг 2018 оны 10 дугаар сард боловсруулан "Нарийнсухайтын төмөр зам" ХХК-аас санал авахаар өнгөрсөн онд албан бичиг хүргүүлсэн. Төмөр замын царигийн асуудал Улсын Их | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | доошгүй хувийн оролцоотой “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Ж.Бат-Эрдэнэ, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т тус тус даалгасугай. | Хурлаас эцэслэн шийдвэрлэгдсэний дараа гэрээ байгуулах асуудлаар санал солилцох тухайгаа тухайн үед “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-иас мэдэгдсэн.<br>УИХ-ын ЭЗБХ-ны 2019 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын царигийн хэмжээг 1435 мм байхаар тогтох тухай асуудлыг хэлэлцэж, УИХ-ын 64 дүгээр тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай УИХ-ын тогтоолын төслийг анхны хэлэлцүүлгээр батлуулах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан.<br>УИХ-аар хэлэлцэхээр хүлээгдэж байгаа бөгөөд царигийн өргөний хэмжээг УИХ-аар тогтоосны дараа барилгын ажлыг эхлүүлнэ. | | |
| 19 | 28 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1. Дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт үүрэг болгосугай: 1.1. харьяа байгууллага болон салбар, нэгжид сахилга, дэг журмыг сахиулах тодорхой арга хэмжээ авч, төрийн албаны хууль тогтоомж, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн төрийн албан хаагчид хариуцлага тооцож тухай бүр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тайлагнаж байх; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”, албан тушаалын тодорхойлолт, 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ажил, үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй, ажлын цагийн хоцрогдолтой зөрчил гаргасан албан хаагч байхгүй тул хариуцлага тооцогдоогүй байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |
| | 29 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.3. төрийн албан хаагчдын ажлын байрны шинжилгээ хийж, шинжилгээний дүнд тулгуурлан байгууллагын чиг үүргийн давхардал, хийдлийг арилгаж, ажлын бүтээмж, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2019 он гарсаар УИХ, ЗГ, ТАЗ-өөс шинээр болон шинэчлэн баталсан журмыг байгууллагын хэмжээнд мөрдүүлэхээр зохион байгуулалтын арга хэмжээ аван ажиллаж байна. Албан хаагчдын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг сайжруулах, сахилга хариуцлагыг чангатгах зэрэг асуудлыг тодорхой болгох зорилгоор дотоод журам, дүрмийг тодотгох, шинэчлэн боловсруулах ажлыг хийж байна. Тайлант хугацаанд “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ыг шинэчлэн боловсруулж, ТӨБЗГ-ын даргын 2019 оны А-163 дугаар тушаалаар батлан мөрдүүлэв. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ыг мөрдөх, байгууллага, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор байгууллага, нэгжийн чиг үүргийн шинжилгээг хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2019 оны А-86 дугаар тушаалаар байгуулан ажиллуулж байна. Ажлын хэсгээс зохион байгуулсны дагуу нэгжүүдийн чиг үүргийн шинжилгээг хэлтэс, алба бүр хийсэн. Ажлын хэсгээс уг шинжилгээг боловсронгүй болгон иж бүрэн шинжилгээ хийхээр чиг үүргийн давхардал, хийдлийг судлан, дүгнэлт гаргасны дүнд байгууллага, албан хаагчдын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн чиг үүргийн дахин хуваарилалтыг хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахаар бэлтгэж байна. Ажлын хэсгээс байгууллагын чиг үүргийн шинжилгээг Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу урьдчилсан байдлаар хийгээд байна. | | |
| | 30 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.4. төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх; | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>2019 оны хагас жилийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн захиргааны 5 хаагчийг чөлөөлсөн бөгөөд тэдгээр сул орон тоонд эрүүл мэндийн шалтгааны улмаас чөлөөтэй байсан 1 албан хаагчийг эргүүлэн, 2 албан хаагчийг байгууллага дотроосоо, 1 албан хаагчийг удирдах албан тушаалтны нөөцөөс нөхөн томилж, 1 албан тушаалын сул орон тоонд төрийн албаны нөөцөөс нөхөн томилохоор хүлээж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 31 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.6. төрийн жинхэнэ албан хаагч жирэмсний болон амаржсны амралттай байгаа, эсхүл 3 сараас дээш хугацааны сургалтад хамрагдаж сул орон тоо гарснаас бусад тохиолдолд төрийн албаны сул орон тоонд гэрээт ажилтан томилохгүй байх зарчим баримталж, төрийн байгууллагад албан ажлын зайлшгүй шаардлагыг үндэслэн богино | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>2019 оны эхний улиралд жирэмсний болон хүүхэд асрах чөлөөтэй 4 албан хаагч, 2 жилийн хугацаатай гадаадад магистрын сургалтад хамрагдаж байгаа 1 албан хаагч, нийт 5 албан хаагчийн оронд нийт 4 албан хаагчийг түр ажиллуулж байна. Гэрээт ажилтан ажиллаагүй болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хугацаагаар ажиллуулахаас бусад тохиолдолд гэрээт ажилтан ажиллуулахгүй байх; | | | |
| | 32 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.7. төрийн албан хаагч албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх явдлыг таслан зогсоох, төрийн байгууллагын байр, ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг байгууллагын дотоод журамд тусган хориглож, зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцох; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ыг газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, уг журмын 7.2.3-т ажлын байр, хууль, журмаар тогтоосон албан үүрэгтэй холбоотой газар ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглосон заалт оруулсан. 2019 оны хагас жилийн байдлаар ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчил гараагүй болно. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| | 33 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.8. төрийн албан хаагчдын үйлдсэн гэмт хэрэг, гаргасан зөрчил, сахилга, ёс зүйн зөрчилд судалгаа, дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг тогтоон, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>"Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам", албан тушаалын тодорхойлолт, 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон ажил, үүргээ хангалтгүй биелүүлсэн, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй, ажлын цагийн хоцрогдлын зөрчил гаргасан албан хаагч байхгүй тул хариуцлага тооцсон тохиолдол гараагүй байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100 % | |
| | 34 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.9. төрийн байгууллагад ажлын цаг ашиглалтыг хурууны хээний болон камерын хяналтын системээр байнга бүртгэж, түүнд тавих хяналтыг сайжруулах; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтыг цаг бүртгэлийн төхөөрөмжөөр бүртгэдэг бөгөөд хяналтыг сайжруулах, ажлыг албан хаагчдын цалинтай уялдуулах замаар зохион байгуулж, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ыг газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, уг журмын 9.2.4-д "Албан хаагч нь нэг сард хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 8 цагаас дээш хугацаагаар хоцорсон, бүртгүүлээгүй тохиолдолд 1 өдрийн ажил тасалсанд тооцно", 9.2.7-д "Захиргаа, хууль зүйн нэгж нь албан хаагчийн цагийн бүртгэлийг системийн дагуу баталгаажуулах бөгөөд уг бүртгэл нь | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | цалин хөлсийг тооцох үндэслэл болно", 9.2.8-д "Албан хаагч нь сард 1 өдөр ба түүнээс дээш хугацаагаар ажил тасалсан нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" зэрэг өөрчлөлтүүдийг оруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн албан хаагчдын цагийн бүртгэлийг 7 хоног бүр газрын шуурхайд танилцуулж хэвшсэн.байна. | | |
| | 35 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>1.10. ажлын байран дахь бүх хэлбэрийн хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг таслан зогсоож, ийм үйлдэл гаргасан албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын талаар байгууллагын дотоод журамд тусган мөрдүүлж, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх арга хэмжээ авах; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Ажлын байран дахь хууль бус дарамт шахалт, ялгавартай хандах үйлдлийг гаргахгүй, эерэг уур амьсгалтай, сэтгэл зүйн дарамтгүй ажиллах орчныг бүрдүүлэх зорилгоор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ыг газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, уг журмын газрын эдлэх эрх, хүлээх үүрэг буюу 7.1.8-д "Албан хаагчийн нэр төрд халдах, доромжлох зэрэг аливаа зүй бус үйлдэл гаргахгүй байх үүрэгтэй", 7.1.9-д "Албан хаагчийг бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах нөхцөл болон хууль тогтоомжоор тогтоосон бусад баталгаагаар хангах үүрэгтэй" байхаар зохицуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| | 36 | **Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2018-08-22, № 258<br>3. Төрийн албаны соёл, дэг журмыг сахиулах, ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор гэнэтийн болон төлөвлөгөөт хяналт шалгалтыг холбогдох байгууллагатай хамтран төрийн байгууллагуудад тогтмол зохион байгуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатарт, өөрийн эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын агентлаг, төрийн бусад байгууллагад хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дарга нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ыг газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, уг тушаалын 9.2.5-д "Ажлын цагийн бүртгэл, цаг ашиглалтад Захиргаа, хууль зүйн нэгж хяналт тавьж ажиллана" гэсэн зохицуулалтыг оруулан, газрын албан хаагчийн ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор 7 хоногт нэг удаа ажлын байран дахь гэнэтийн шалгалтыг хийж хэвшсэн. Тайлант хугацаанд ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй, удирдлагын зөвшөөрөлгүйгээр ажлын байр орхин явсан зөрчил гараагүй байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20 | 37 | **Үл хөдлөх хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах тухай**<br>2018-09-12, № 286<br>1. Цагдаагийн ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 5986 м.кв талбай бүхий 5 барилгыг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Нямт-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Хөрөнгийн болон газар эзэмших эрхийн үнэлгээ хийх этгээдийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2018 оны А/268 дугаар тушаалаар байгуулсан. Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийлгэх тухай зарыг Зууны мэдээ сонины 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдөр, Өдрийн сонин, Өнөөдөр, Зууны мэдээ сонины 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дугааруудад зарыг нийтлэн нийтэд мэдээллийг хүргэсэн. Үнэлгээний зөвлөх үйлчилгээ хийх этгээдийг сонгон шалгаруулах ажиллагааг 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр явуулж, "Итгэлт бээс" ХХК шалгарсан. Тус компанитай үнэлгээ хийх гэрээ байгуулсан бөгөөд Үнэлгээний тайланг хугацаандаа ирүүлээд байна.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 59 дүгээр тогтоолоор Тээврийн цагдаагийн албаны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 барилга байгууламжийг газар эзэмших эрхийн хамт 17,333,000,000.00 (Арван долоон тэрбум гурван зуун гучин гурван сая) төгрөгөөр нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн.<br>Дээрх шийдвэрийн дагуу 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Өнөөдөр", "Зууны мэдээ", "Засгийн газрын мэдээ" сонин болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын www.pcsp.gov.mn цахим хуудсанд зар мэдээг байршуулсны дагуу 2019 оны 03 дугаар сарын 27, 04 дүгээр сарын 17-ны өдөр нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулахад нэг ч оролцогч ирээгүй болно.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны "Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 128 дугаар тогтоолын 5.4-т "Эд хөрөнгө эхний дуудлагын худалдаагаар зарагдаагүй бол дуудлагын худалдааг дахин явуулах, мөн зарагдаагүй тохиолдолд худалдах доод үнийг шинэчлэн тогтоож гурав дахь дуудлагын худалдааг зарлах" гэсний дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор доод үнийг 20 хувь бууруулж, 13,867,800,000.00 (арван гурван тэрбум найман зуун жаран долоон сая найман зуун мянган) төгрөгөөр тогтоон 2019 оны 05 дугаар сарын 24, 06 дугаар сарын 12-ны өдөр нээлттэй дуудлагын худалдааг зохион байгуулахад мөн нэг ч санал ирүүлээгүй болно. | "Хэрэгжих шатанд" – 70% | |
| 21 | 38 | **Хорих анги болон төрийн өмчит үйлдвэрийн газар татан буулгах тухай**<br>2018-10-10, № 304<br>3. Татан буугдсан хорих ангиудын эд хөрөнгө, төсөв, санхүү, орон тоог хууль | **ТӨБЗГ – БТУХ**<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар Татан буулгах ажлын хэсэг томилогдон хууль тогтоомжид заасны дагуу "Авдрант хайрхан" төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын өр, авлагыг барагдуулан, эд хөрөнгө болон холбогдох ажиллагсдыг | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | тогтоомжид заасны дагуу шилжүүлэх арга хэмжээ авахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид, “Авдрант хайрхан” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг татан буулгах ажлыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Ц.Амгаланбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осор нарт тус тус даалгасугай. | харьяа байгууллагуудад шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. Татан буулгах ажлын хүрээнд “Авдрант хайрхан” ТӨААТҮГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9,898,276.43 төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах тухай зөвшөөрлийг ТӨБЗГ-ын 2019 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А-4/292 дугаар албан бичгээр шийдвэрлэсэн.<br><br>Татан буулгах, хөрөнгийг шилжүүлэх ажил бүрэн хийгдэж дууссан. | | саналтай. |
| 22 | 39 | **“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай**<br><br>2018-10-31, № 328<br><br>2. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрмийн төслийг боловсруулж, БХБЯ-аас санал авч тусган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 23 дугаар тогтоолоор баталсан. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| | 40 | **“Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит үйлдвэрийн газрыг өөрчлөн байгуулах тухай**<br><br>2018-10-31, № 328<br><br>3. “Төрийн орон сууцны корпораци” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, компанийн өр, авлагыг барагдуулах талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Барилга, хот байгуулалтын сайд Х.Баделхан, Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) нарт тус тус даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Хөгжлийн банкны зээлээр барьж буй байруудыг “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт хамруулах тухай Засгийн газрын 2018 оны 81 дүгээр тогтоол гарсантай холбогдуулан 82.3 тэрбум төгрөгийн үнэ бүхий орон сууцыг Түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн. Энэхүү үнийн дүнг “Төрийн орон сууцны корпораци” ТӨҮГ-т олгох ёстой тул БХБЯ-наас 2019 оны улсын төсөвт нийт 5.0 тэрбум төгрөгийг тусгасан. Цаашид дээрх дүнг улсын төсөвт үе шаттай тусгах замаар асуудлыг шийдвэрлэнэ.<br><br>Тус компанийг Төлөөлөн удирдах зөвлөлтэй болгож, төрийн өмчийн төлөөллөөр дамжуулан удирдлага, менежментийг сайжруулах арга хэмжээ аван ажиллаж байна. “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийг Барилга, хот байгуулалтын яам, Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төлөөллийг оролцуулан нийт 7 гишүүнтэйгээр байгуулсан болно. | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 23 | 41 | **“Мон-Атом” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-01-09, № 4<br>2.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Мон-Атом” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-д холбогдох хууль тогтоомжийн дагуу шилжүүлэх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат), “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Г.Баясгалан)-д даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны А-1/258 дугаар албан бичгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт хүргүүлж, “Мон-Атом” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрхийг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэн бүртгэхийг хүсэлт тавьсан. Хувьцаа эзэмшигчийн эрхийг шилжүүлэх бүртгэл бүрэн хийгдсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 24 | 42 | **2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгох тухай**<br>2019-01-16, № 23<br>3.Хавсралтаар төлөвлөгөөг оруулав. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг эрхлэх ажлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулж, ажлын тайланг улирал тутам Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай. Жич: Хавсралтаар оруулсан “ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ-ний дагуу өөрийн нэр заасан ажлыг хүснэгтээр гаргаж тайлагнана. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>“Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн байгууллагад хамаарал бүхий нийт 5 бодлогын зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 13 зорилт бүхий 21 арга хэмжээг хянатад аван хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. 2019 оны 1 дүгээр улирлын тайланг 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А-2/842 дугаар албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн бөгөөд Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ мэдээллийн цахим системд оруулан тайлагнаж, Засгийн газрын хяналт, үнэлгээнд хамруулсан болно.<br>2019 оны 1 дүгээр улирлын байдлаар, жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг танилцуулбал,<br>– 100% буюу “Бүрэн хэрэгжсэн” үнэлгээтэй – 6 арга хэмжээ;<br>– 70 % буюу “Хэрэгжих шатанд” үнэлгээтэй – 1 арга хэмжээ;<br>– 30% буюу “Хэрэгжилт хангалтгүй” үнэлгээтэй – 12 арга хэмжээ;<br>– 0 % буюу “Хэрэгжээгүй” үнэлгээтэй – 2 арга хэмжээ;<br>– “Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй” – 0 арга хэмжээ;<br>– Хэрэгжилтийн дундаж хувь – 49.05 %.<br>Жилийн ажлын эхний хагас жилийн тайланг нэгтгэн боловсруулж байгаа бөгөөд дүн эцэслэн гараагүй байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 25 | 43 | **Дүрэм батлах тухай (“Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”)**<br>2019-01-23, № 33 | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Ёс зүйн зөвлөл” газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/141 дүгээр тушаалаар байгуулагдан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг “Төрийн захиргааны болон | “Хэрэгжилт хангалтгүй” – 30% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | 2.Байгууллагын дотоод журмыг энэ тогтоолоор баталсан дүрэмд нийцүүлэн баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг төсвийн шууд захирагч нарт даалгасугай. | үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д нийцүүлэн шинэчлэн боловсруулж байна. | | |
| 26 | 44 | **2019 оныг "Эх оронч худалдан авалтын жил" болгох тухай**<br>2019-01-30, № 59<br>3.Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, эрхэлсэн салбар, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжилтийг зохион байгуулж, тайланг хагас болон жилийн эцсийн байдлаар Аж үйлдвэржилтийн бодлогын зөвлөлд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ХААХ**<br>Засгийн газрын 2018 оны 388 болон 2019 оны 46 дугаар тогтоолуудаар батлагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хэрэгжүүлэх 169 төсөл, арга хэмжээний жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн, чанар стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүн худалдан авах боломж бүхий барааны төсөл, арга хэмжээ тусгагдаагүй, одоогийн байдлаар ийм төсөл, арга хэмжээний эрх шилжиж ирээгүй байна.<br>Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор үндэсний үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн, чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг барилга угсралтын ажилд ашиглахаар бол бараа материал болон ажиллах хүчний хувьд дотоодын давуу эрх тооцохоор тендерийн баримт бичигт тусгасан. 2019 оны эхний хагас жилийн байдлаар, 135 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулж байгаа бөгөөд тендерийн нээлт хийгдсэн 63 төсөл, арга хэмжээнээс 20 төсөл, арга хэмжээнд оролцогч 39 компанид 6.2 тэрбум төгрөгийн дотоодын давуу эрхийн зөрүүг тооцоод байна.<br>Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны жагсаалт"-д тусгагдсан "Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах" төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна. Ерөнхий гэрээний энэхүү худалдан авалтын хүрээнд 32 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 17 аж ахуйн нэгжтэй 47 ерөнхий гэрээ байгуулсан бөгөөд 10 (31.3%) нэр төрлийн эмийн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авч, эм, эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэлтийг хийж, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжсэн байна. | "Бүрэн хэрэгжсэн" - 100% | |
| | 45 | **2019 оныг "Эх оронч худалдан авалтын жил" болгох тухай**<br>2019-01-30, № 59<br>4."Эх оронч худалдан авалтын жил"-ийн хүрээнд дотоодод үйлдвэрлэсэн | **ТӨБЗГ – ХААХ**<br>Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд ХХААХҮЯ-тай хамтран "Монголд үйлдвэрлэв" 2017, 2018 оны дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний каталогийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ийн "Цахим дэлгүүр" хэсэгт | "Бүрэн хэрэгжсэн" - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | үндэсний бараа, бүтээгдэхүүнийг худалдан авч хэрэглэхийг нийт аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд уриалсугай. | байршуулж, худалдан авах ажиллагаанд оролцогч захиалагч, нийлүүлэгчдэд сурталчлан танилцуулав.<br><br>Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх дэмжих зорилгоор тус газраас зарласан нийт тендер шалгаруулалтад дотоодод үйлдвэрлэсэн чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүн ашиглах бол давуу эрх олгохоор тендерийн баримт бичигт тусгайлан зааж байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар, 135 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулж байгаа бөгөөд тендерийн нээлт хийгдсэн 63 төсөл, арга хэмжээнээс 20 төсөл, арга хэмжээнд оролцогч 39 компанид 6.2 тэрбум төгрөгийн дотоодын давуу эрхийн зөрүүг тооцоод байна. | | |
| 27 | 46 | **Орон сууц хувьчлах тухай**<br><br>2019-02-13, № 61<br><br>2.Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор орон сууц өмчлөх эрхийг шилжүүлэн олгуулахаар Сэлэнгэ аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны А-1/781, Орхон аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 2019 оны А-1/782 дугаар албан бичгийг хүргүүлэн орон сууц эзэмшигчдэд өмчлөх эрхийг шилжүүлэн олгох ажлыг зохион байгуулсан болно. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 28 | 47 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2019-03-06, № 31<br><br>2.1. компанийн статусыг өөрчлөн зохион байгуулах хүртэл компанийн дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг тогтоож, бүх шатны удирдах ажилтныг томилохыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбат нарт; | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Компанийн статусыг өөрчлөн зохион байгуулах хүртэл хугацаанд дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг тогтоож, бүх шатны удирдах ажилтныг томилох талаар ажлын хэсэг гарч ажиллан “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн бүх шатны удирдах ажилтныг томилуулан хэрэгжилтийг хангасан. Холбогдох шийдвэрүүдийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| | 48 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2019-03-06, № 31<br><br>2.3. үндсэн ба эргэлтийн хөрөнгө, түүний дотор түүхий эд, материалын | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Үндсэн ба эргэлтийн хөрөнгө, түүний дотор түүхий эд, материалын нийлүүлэлт, зарцуулалт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хадгалалт, хуваарилалт, тээвэрлэлт, борлуулалтад тусгай хяналт тогтоож ажиллаж, долоо хоног бүр мэдээллийг Засгийн газарт хүргүүлэн ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нийлүүлэлт, зарцуулалт, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хадгалалт, хуваарилалт, тээвэрлэлт, борлуулалтад тусгай хяналт тогтоож ажиллахыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбат нарт; | | | |
| | 49 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-03-06, № 31<br>2.4. шаардлагатай бол тухайн компанид хөдөлмөрийн болон үйлдвэрлэл, технологийн сахилгыг чанд сахин биелүүлэхэд чиглэсэн хөдөлмөрийн сахилгын тухайлсан дүрэм, үйлдвэрлэлийн аюул осолгүй ажиллагааны болон олон нийтийн хэв журам сахиулах тусгай журам тогтоож, тэдгээрийг зөрчигчдөд зохих хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбат нарт; | **ТӨБЗГ – БТУХ**<br>Ийм шаардлага одоогоор гараагүй болно. Тухайн компанид хөдөлмөрийн болон үйлдвэрлэл, технологийн сахилгыг чанд сахин, үйлдвэрлэлийн аюул осолгүй ажиллагааны болон олон нийтийн хэв журам сахиулан ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |
| | 50 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-03-06, № 31<br>2.6. онцгой дэглэмтэй компанийн эрх ашиг сонирхолд нийцээгүй гэрээг талуудын хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүйгээр өөрчлөх буюу цуцлах арга хэмжээ авч ажиллахыг “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбат нарт; | **ТӨБЗГ – БТУХ**<br>Онцгой дэглэмтэй компанийн эрх ашиг сонирхолд нийцээгүй гэрээ одоогийн байдлаар тогтоогдоогүй байна. | Хугацаа болоогүй – Үнэлэх боломжгүй. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 51 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-03-06, № 31<br>2.7. хууль тогтоомжоор улс, орон нутгийн төсөвт төлөх татвар, хураамж, ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат), “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Бадамсүрэн, “Монголросцветмет” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Мөнхбат нарт. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Хууль тогтоомжийн хүрээнд улс, орон нутгийн төсөвт төлөх татвар, хураамж, ногдол ашгийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавин ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 52 | **“Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-03-06, № 31<br>3.Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолын 2-т заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ХХК, Монголросцветмет ХХК-ийг төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар өөрчлөн зохион байгуулах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолын 2-т заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийг төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар өөрчлөн зохион байгуулах тухай тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэн ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2019 оны 102, 103 дугаар тогтоолоор тус компаниудыг төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, дүрмийг баталсан. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 29 | 53 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2019-03-06, № 92<br>2.Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгасугай. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн А/159 дүгээр тушаалаар үл хөдлөх хөрөнгө хүлээлцэх ажлын хэсэг газар дээр нь ажиллан хүлээлцсэн. Мэргэжлийн боловсрол, сургалт, үнэлгээний төв 299,000,000.00 төгрөгөөр балансандаа бүртгэж авсан. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 30 | 54 | **“Эрдэнэт үйлдвэр” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулах тухай**<br>2019-03-21, № 102<br>3.“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлэх, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоон мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоон, 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, мөрдүүлэн ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 31 | 55 | **“Монголросцветмет” хязгаарлагдмал хариуцлагатай компанийг төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулах тухай**<br>2019-03-21, № 103<br>3.“Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлэх, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоон мөрдүүлэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг улсын бүртгэлд бүртгүүлсэн. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарыг тогтоон, 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, мөрдүүлэн ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” - 100% | Бүрэн хэрэгжсэн тул хяналтаас хасах саналтай. |
| 32 | 56 | **Төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай**<br>2019-03-21, № 111<br>2.Бүх шатны төсвийн байгууллага, төрийн буюу орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг тогтоосон хувь хэмжээгээр ажиллуулах, ажиллуулаагүй тохиолдолд зохих төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br>Тус байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүн ажиллаагүй байна. | Хугацаа болоогүй – Үнэлэх боломжгүй. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 33 | 57 | **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв байгуулах тухай**<br><br>2019-04-03, № 125<br><br>2.5. Эдийн засаг, техникийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын 2016 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн хэлэлцээрийн дагуу “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв барих” төслийн хүрээнд бий болсон хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн өмчид бүртгэхийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т. | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br><br>Холбогдох байгууллагаас үндсэн хөрөнгөд бүртгэх зөвшөөрөл авах тухай хүсэлтээ албан бичгээр ирүүлээгүй тул хүлээгдэж байна. | Хугацаа болоогүй – Үнэлэх боломжгүй. | |
| 34 | 58 | **Төрийн үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай**<br><br>2019-04-17, № 149<br><br>3.Иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхэд төрийн мэдээллийн сангаас гарах боломжтой лавлагаа, мэдээллийг шаардахгүй байх зарчмыг баримтлан технологийн дэвшлийг ашиглаж төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд хандан авах замаар шийдвэрлэх, “Үйлчилгээний нэгдсэн төв”-д ажиллах байгууллагын албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэхийг холбогдох сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгаж, Шүүхийн ерөнхий зөвлөл (Н.Лүндэндорж)-д зөвлөсүгэй. | **ТӨБЗГ – ЗХЗХ, МТА**<br><br>“ХУР” системтэй мэдээлэл солилцох тухай гэрээг 2018 онд байгуулан худалдан авах ажиллагаанд шаардлагатай мэдээллийг төрийн бусад байгууллагаас шуурхай авч ашиглаж байна. Худалдан авах ажиллагаанд шаардлагатай мэдээлэл солилцох асуудлыг шийдвэрлэх зорилгоор Авто тээврийн үндэсний төвийн веб сервисийн холболтын ажлыг эхлүүлсэн. | “Хэрэгжих шатанд” - 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 35 | 59 | **Монгол-Хятадын хамтарсан компани байгуулах тухай**<br>2019-04-23, № 164<br>2.Монгол-Хятадын хамтарсан компани байгуулах, үйл ажиллагааг нь тогтворжуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энх-Амгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т тус тус үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Монголын төмөр зам” ТӨХК нь төсөлд хөрөнгө оруулах чадамжтай хувийн хэвшлийн этгээдээр шалгарсан "Монголиа уул уурхайн хөрөнгийн менежмент" ХХК-тай хамтарсан төслийн зориулалттай "Монголиан порт групп" ХХК-ийг “Монголын төмөр зам” ТӨХК -ийн 51 хувь, "Монголиа уул уурхайн хөрөнгийн менежмент" ХХК-ийн 49 хувийн оролцоотойгоор байгуулсан. 2019 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Хятадын “Тяньжин порт” төрийн өмчит компанийн охин компани болох “Тяньжин портын эдийн засаг, технологийн хамтын ажиллагаа” ХХК-тай “Хятад Монголын Олон Улсын ложистик бүс” компанийг байгуулах гэрээнд гарын үсэг зурсан. Ингэснээр Тяньжин хотын Дуньзян чөлөөт худалдааны боомт бүсэд Хятадын талтай хамтарсан тээвэр ложистикийн төсөл хэрэгжүүлэх “Хятад Монголын Олон Улсын ложистик бүс” компанийг амжилттай байгуулаад байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| | 60 | **Монгол-Хятадын хамтарсан компани байгуулах тухай**<br>2019-04-23, № 164<br>3. Монгол-Хятадын хамтарсан компани байгуулах гэрээ, компанийн дүрмийн хэрэгжилтийг хагас жил тутам Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнахыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Р.Мэргэн), “Монголиан порт групп” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Цэнгэл)-д үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Монгол-Хятадын хамтарсан компани байгуулах гэрээ, компанийн дүрмийн хэрэгжилтийг хагас жил тутам Зам, тээврийн хөгжлийн яаманд тайлагнаж байх талаар удирдамж, чиглэл өгч ажиллав. | “Хэрэгжих шатанд” – 70% | |
| 36 | 61 | **Мал хамгаалах сангийн талаар авах арга хэмжээний тухай**<br>2019-05-01, № 179<br>4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Мал хамгаалах сангийн ажлын албыг татан буулгах комиссыг томилж, татан буугдсан ажлын албаны эд хөрөнгөд тооллого хийх, үндсэн болон бусад эд хөрөнгө, өр, авлагыг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд шилжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд | **ТӨБЗГ – ТӨБХХ**<br>Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/155 дугаар тушаалаар Мал хамгаалах сангийн ажлын албыг татан буулгах комиссыг байгуулсан.<br>Комисс нь татан буугдсан ажлын албаны эд хөрөнгөд тооллого хийх, үндсэн болон бусад эд хөрөнгө, өр, авлагыг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, ХХААХҮЯ-нд шилжүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна. | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Ч.Улаан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгасугай. | | | |
| 37 | 62 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-05-01, № 186<br>2.”Биокомбинат” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтэц, төсвийн баталж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 188 дугаар тогтоолоор “Биокомбинат” аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгаж, улсын төсөвт үйлдвэрийн газар болгохоор шийдвэрлэсний дагуу ХХААХҮ-ийн сайдын тушаалаар татан буулгах комисс байгуулагдсан. ТӨБЗГ-ын тогтоолоор хаалтын баланс гарч, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газарт татан буулгах хүсэлт явуулсан боловч хүсэлтийг одоог хүртэл шийдвэрлээгүй байна.<br>Иймд тус үйлдвэрийн газрын статусын маргаантай асуудлыг шийдвэрлэсний дараа Засгийн газрын энэ шийдвэрийг хэрэгжүүлэх боломжтой. | Хугацаа болоогүй – Үнэлэх боломжгүй. | |
| | 63 | **Төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар авах зарим арга хэмжээний тухай**<br>2019-05-01, № 186<br>3.”Биокомбинат” төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг байгуулсантай холбогдуулан гүйцэтгэх удирдлагыг мэргэжлийн багаар гүйцэтгүүлэн ажиллуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 188 дугаар тогтоолоор “Биокомбинат” аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газрыг татан буулгаж, улсын төсөвт үйлдвэрийн газар болгохоор шийдвэрлэсний дагуу ХХААХҮ-ийн сайдын тушаалаар татан буулгах комисс байгуулагдсан. ТӨБЗГ-ын тогтоолоор хаалтын баланс гарч, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газарт татан буулгах хүсэлт явуулсан боловч хүсэлтийг одоог хүртэл шийдвэрлээгүй байна.<br>Иймд тус үйлдвэрийн газрын статусын маргаантай асуудлыг шийдвэрлэсний дараа Засгийн газрын энэ шийдвэрийг хэрэгжүүлэх боломжтой. | Хугацаа болоогүй – Үнэлэх боломжгүй. | |
| | | **ЗГТогтоол: 33 шийдвэрийн 58 заалт** | **100% - 30 заалт; 70% - 17 заалт; 30% - 3 заалт; ХБ/ҮБ – 8 заалт; Хэрэгжилтийн хувь – 85.6%.** | | |
| **Тав. Ерөнхий сайдын захирамж** | | | | | |
| 38 | 64 | **Ажлын хэсэг байгуулах тухай**<br>2018-04-05, № 66<br>2. Улсын Их Хурлын 2002 оны 56 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал | **ТӨБЗГ – БТУХ**<br>“Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, цаашид тус салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх саналыг боловсруулан Засгийн газарт танилцуулах үүрэг бүхий ажлын хэсэг Ерөнхий сайдын 2018 оны 66 дугаар захирамжаар байгуулагдсан. Улсын Их Хурлын 2002 оны 56 | Хугацаа болоогүй” – Үнэлэх боломжгүй. | ТӨБЗГ-аас хамаарах-гүйгээр удааширч байгаа. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хийх үндсэн чиглэл"-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, цаашид тус салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх саналыг холбогдох шийдвэрийн төслийн хамт боловсруулж 2018 оны 6 дугаар сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Г.Занданшатар)-т даалгасугай. | дугаар тогтоолоор батлагдсан "Нийгмийн салбарт өөрчлөлт, шинэчлэл, хувьчлал хийх үндсэн чиглэл", Засгийн газрын 2003 оны 34 дүгээр тогтоолын хэрэгжилт, биелэлтийг ТӨБЗГ-аас Ажлын хэсгийн гишүүдэд хүргүүлсэн болно. Ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэж, гарах шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах болно. | | |
| 39 | 65 | **Ажлын хэсэг байгуулах тухай**<br>2019-02-26, № 21<br>2.Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн "Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай: Тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар тухай бүр танилцуулж байхыг Ажлын хэсэг /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Ерөнхий сайдын 2019 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 24 дүгээр захирамжаар хүчингүй болгосон. | Хугацаа болоогүй - Үнэлэх боломжгүй. | Хүчингүй болсон тул хяналтаас хасуулах саналтай. |
| 40 | 66 | **Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай**<br>2019-03-04, № 24<br>2.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2019 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн Н05/05 дугаар зөвлөмжийн 2 дахь хэсгийн 2-т заасныг үндэслэн Улсын Их Хурлын 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн "Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 23 дугаар тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай: Тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар тухай бүр танилцуулж байхыг Ажлын хэсэг (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Улсын Их Хурлын 2017 оны 23 дугаар тогтоолын 2-т заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Эрдэнэт үйлдвэр" ХХК, "Монголросцветмет" ХХК-ийг төрийн өмчит үйлдвэрийн газрын статустайгаар өөрчлөн зохион байгуулах тухай тогтоолын төсөл, танилцуулгыг бэлтгэн ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж шийдвэрлүүлсэн. Засгийн газрын 2019 оны 102, 103 дугаар тогтоолоор тус компаниудыг төрийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, дүрмийг баталсан. | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **ЕС-ын захирамж:**<br>**3 шийдвэрийн 3 заалт** | **70% - 1 заалт; ХБ/ҮБ - 2 заалт; Хэрэгжилтийн хувь – 70.0%.** | | |
| **Зургаа. Засгийн газрын хуралдааны тэмдэглэл** | | | | | |
| 41 | 67 | **Худалдан авах ажиллагааны тухай**<br>2016-09-28, № 48<br>XYII.2.6. Төсвийн байгууллагын байнгын хэрэгцээтэй бараа, ажил, үйлчилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.11-д заасны дагуу ерөнхий гэрээ байгуулан, мөн хуулийн 10[1] дүгээр зүйл, 53.5.7-д заасны дагуу тус тус зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор) болон бүх шатны төсвийн шууд захирагч нарт үүрэг болгов. | **ТӨБЗГ – МТА**<br>Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-д “Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” ажил тусгагдсан. Энэхүү ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://tender.gov.mn -ийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр дамжуулан Монгол улсад 2 дахь жилдээ зохион байгуулж байна. Зарим ерөнхий нэршлийн 32 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл хانган нийлүүлэх 17 аж ахуйн нэгжтэй давхардсан тоогоор 47 ерөнхий гэрээ байгуулсан. 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд нийт 712 удаагийн захиалга хийгдэж, 3.9 тэрбум төгрөгийн 32 нэр төрлийн эм, хэрэгсэл борлуулагдан улсын төсөвт 165.2 сая төгрөгийн хэмнэлт гарсан. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 42 | 68 | **Үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай**<br>2017-08-17, № 36<br>III.2. Яам, Засгийн газрын агентлаг, төсөвт байгууллагын харьяанд ажилладаг амралтын газрын талаар болон төсвөөс санхүүжүүлдэг амралтын газрыг худалдах, хувьчлах саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Ням-Осорт даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Яам, Засгийн газрын агентлаг, төсөвт байгууллагын харьяанд ажилладаг амралтын газар болон төсвөөс санхүүжүүлдэг амралтын газар, түүний хөрөнгийн бүртгэл, санхүүжилтийн талаар судалгаа хийж, нэгдсэн мэдээлэл гаргасан. Тус мэдээлэлд дүн шинжилгээ хийн холбогдох байгууллагуудын саналыг авахаар ажиллаж байна. | Хэрэгжээгүй – 0% | 3 тайлан-гийн хугацаанд өөрчлөлт ороогүй, ахицгүй. |
| 43 | 69 | **Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай**<br>2017-09-13, № 39<br>XXII.2.1. 2017 онд худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль тогтоомжийн дагуу дотоодын аж ахуйн нэгж, үйлдвэрлэгчийг давуу эрхээр | **ТӨБЗГ – ХААХ**<br>2019 онд ТӨБЗГ-аас зохион байгуулах худалдан авах ажиллагааны жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн чанар, стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн худалдан авах боломж бүхий барааны төсөл, арга хэмжээ тусгагдаагүй. Мөн энэ төрлийн барааны худалдан авах ажиллагаа эрх шилжиж ирээгүй байна.<br>Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор тус газраас зарласан нийт | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | шалгаруулж байгааг сайшаан, цаашид дотоодын аж ахуйн нэгж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгов | тендер шалгаруулалтын дүнд гүйцэтгэх ажилд дотоодод үйлдвэрлэсэн чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүн ашиглах бол давуу эрх олгохоор тендерийн баримт бичигт тусгайлан зааж байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар тендерийн нээлт хийж, үнэлгээ явагдсан 63 төсөл, арга хэмжээнээс тендер шалгаруулалтад хүсэлт ирүүлсэн, 20 төсөл, арга хэмжээнд оролцогч 39 компанид 6.2 тэрбум төгрөгийн дотоодын давуу эрхийн зөрүү олгов. | | |
| | 70 | **Худалдан авах ажиллагааг зохион байгуулах тухай**<br>2017-09-13, № 39<br>XXII.2.2. Төсвийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа худалдан авах ажиллагааны явцын мэдээг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав. | **ТӨБЗГ – ХААХ**<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар шинэчлэн батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу хагас жил, жилийн эцсийн байдлаар ТӨБЗГ-т зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тайланг Сангийн яаманд хүргүүлж байна. ТӨБЗГ-т зохион байгуулсан 2018 оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан, мэдээг нэгтгэн 2019 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А-1/80 дугаартай албан бичгээр Сангийн яаманд шинэчлэгдсэн журмын дагуу хүргүүлсэн.<br>Харин нийслэл, 21 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын худалдан авах ажиллагааны явцын мэдээг сар, улирлаар хүлээн авч, дүн шинжилгээ хийн арга зүйн зөвлөгөө, чиглэл өгч байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| 44 | 71 | **Хэнтий аймгийн Бэрхийн уурхайд ажиллаж байсан иргэдийн нөхөн төлбөртэй холбоотой асуудлын тухай**<br>2018-01-31, № 7<br>XY.5. Хэнтий аймгийн Бэрхийн уурхайд ажиллаж байсан иргэдийн нөхөн төлбөртэй холбоотой асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд С.Чинзориг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч ажиллахыг холбогдох сайд, дарга нарт даалгав: 1. “Бэрх-Уул” төрийн өмчит хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байсан үед буюу 1999-2004 оны хооронд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдаж, тахир | **ТӨБЗГ – БТУХ**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас Засгийн газрын тэмдэглэлээр өгсөн үүргийг хэрэгжүүлэх зорилгоор байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд холбогдох төрийн захиргааны байгууллагаас албан хаагчдыг ажиллуулахаар 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдөр Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд тус тус албан бичиг хүргүүлсэн. Сангийн яам, Хууль зүй, дотоодын хэргийн яамнаас төлөөлөл ажиллахгүй тухай мэдэгдсэн тул 2018 оны 7 дугаар сарын 04-ний өдөр дахин албан бичиг хүргүүлж, заавал салбар яамдын бүрэлдэхүүнийг оролцуулах шаардлагатайг мэдэгдсэн. Сангийн яамнаас 2 удаа татгалзсан хариу ирүүлсэн.<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “Бэрх-Уул” ТӨХК-д ажиллаж байсан ажиллагсдын төлөөлөл Б.Алтангэрэлийн өргөдлийг хүлээн авч, 3 удаагийн уулзалт хийн, ажлын хэсэг байгуулах үйл явцын тухай мэдээлэл өгсөн. Асуудлыг шүүхээр шийдвэрлэх тухай судалж байна. | “Хэрэгжилт хангалтгүй” – 30% | 2 тайлан-гийн хугацаанд ахиц гараагүй, удааширч байгаа. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | дутуугийн тэтгэвэр тогтоолгосон иргэдийн нөхөн төлбөрийн асуудлыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон бусад төрийн байгууллагатай хамтран дахин нягтлан үзэж саналаа Засгийн газарт танилцуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т; | | | |
| 45 | 72 | **Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллагад интернетийн зохистой хэрэглээг бий болгох арга хэмжээний тухай**<br>2018-04-04, № 16<br>XY.2. Ажлын байранд, ажлын цагаар интернэт ашиглан олон нийтийн сүлжээнд нэвтрэх, албан ажилд хамаарахгүй үйл ажиллагаа явуулахыг хориглох асуудлыг байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд тусган хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах арга хэмжээ авч “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нар, бүх шатны Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн захирлуудад үүрэг болгосугай. | **ТӨБЗГ – Бүх хэлтэс, алба**<br>Ажлын байранд ажлын цагаар интернэт ашиглан, олон нийтийн сүлжээнд нэвтрэхгүй байх, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний аюулгүй байдлыг хангаж цахим халдлага, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмж сайжруулах зорилгоор олон нийтийн сүлжээ (facebook, twitter)-д хандах боломжгүй болгож, холбогдох тохиргоог Төрийн холбооны газартай хамтран хийсэн. Мөн “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.1.7-д “Зохистой хэрэглээг тогтоох зорилгоор албан хаагчийн зарим хэрэглээ (албан өрөөний утас, интернэт, албаны автомашин)–нд хязгаарлалт тавих эрхтэй”, 7.3.3-д “Ажлын байранд газрын үйл ажиллагаанд үл хамаарах ажил, үйлчилгээ явуулах”-ыг хориглох тухай заалтыг тусгаж хөдөлмөрийн дотоод журмыг мөрдүүлэн ажиллаж байна. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 73 | **Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, түүний хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнгийн тухай**<br>2018-04-04, № 16<br>XYI.9. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2017 оны худалдан авах ажиллагааны тайлан, түүний | **ТӨБЗГ – ХААХ, МТА**<br>1.1.Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т 100 хувь цахим хэлбэрээр (www.tender.gov.mn) зохион байгуулж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн урилга, үр дүнг тухай бүр цахим системд нийтэлж, олон нийтэд мэдээлж байна. 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, улсын хэмжээнд нийт 10,000 тендер шалгаруулалтын урилга зарлагдсан дүнтэй байна. Үүнээс 9799 буюу 98.0 хувь нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга байна. Цахим тендер шалгаруулалтын урилга өнгөрсөн оны мөн үетэй | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнгийн талаар Сангийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 1.2018 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ, тендер шалгаруулалтын явц 2018 оны I улирлын байдлаар “хангалтгүй” буюу 27.7 хувьтай байх тул тендер шалгаруулалтыг шуурхай зохион байгуулж, Засгийн газрын 2017 оны 337, 2018 оны 34 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажиллах; 1.1.худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нийтлэх, тендерийн урилга, үр дүнг тухай бүр системд оруулж нээлттэй, ил тод байдлыг хангаж ажиллах; 1.2.өөрийн харьяаны 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг нэгтгэн хуульд заасан хугацаанд Сангийн яаманд хүргүүлэх; 1.3.худалдан авах ажиллагааг төлөвлөгөөнд заасан хугацаанд багтаан зохион байгуулж, тайланг бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр тус бүрээр гаргаж тайлагнах; 1.4. барааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн $10^{1}$-д заасны дагуу дотоодын үйлдвэрээс худалдан авах, Засгийн газрын 2015 оны 336 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах. | харьцуулахад, 12 хувиар буюу 3581 урилгаар нэмэгдсэн нь захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, цахим системийн хэрэглээ нэмэгдсэн, худалдан авах ажиллагааны ил тод байдалд ахиц гарсныг харуулж байна.<br>1.2.“Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах тухай журам”-ын дагуу төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын 2019 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлэв. (МТА-цахим системд нийтлүүлэх арга хэмжээ авав).<br>1.3.ТӨБЗГ-т зохион байгуулсан 2018 оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан, мэдээг нэгтгэн 2019 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А-1/80 дугаартай албан бичгээр Сангийн яаманд шинэчлэгдсэн журмын дагуу хүргүүлсэн.<br>1.4.Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор тус газраас зарласан нийт тендер шалгаруулалтын дунд гүйцэтгэх ажилд дотоодод үйлдвэрлэсэн чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүн ашиглах бол давуу эрх олгохоор тендерийн баримт бичигт тусгайлан зааж байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар тендерийн нээлт хийж, үнэлгээ явагдсан 63 төсөл, арга хэмжээнээс тендер шалгаруулалтад хүсэлт ирүүлсэн, 20 төсөл, арга хэмжээнд оролцогч 39 компанид 6.2 тэрбум төгрөгийн дотоодын давуу эрхийн зөрүү олгов. | | |
| | 74 | **Цахим худалдлан авах ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай**<br>2018-04-04, № 16<br>XYI.9.2.Цахим худалдан авах ажиллагаар | **ТӨБЗГ – МТА**<br>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.pcsp.gov.mn -ийн ашиглалтыг нэмэгдүүлэх, цахим худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах зорилгоор цахим худалдан авах ажиллагааны | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | сайжруулах, статистик тоон мэдээллийн давхардалгүй, үнэн зөв байдлыг хангах, ерөнхий гэрээ байгуулах ажлыг эхлүүлэхтэй холбоотойгоор цахим дэлгүүрийн хэвийн ажиллагааг хангаж, холбогдох гарын авлагыг боловсруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Ц.Ням-Осор)-т үүрэг болгов. | системийн сургалтыг худалдан авах ажиллагааны захиалагч байгууллага, тендерт оролцогч аж ахуйн нэгжийн төлөөлөлд зохион байгуулж, 456 албан хаагч, иргэнийг оролцуулав.<br><br>2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, улсын дүнгээр нийт 10,000 тендер шалгаруулалтын урилга зарлагдсан дүнтэй байна. Үүнээс 9799 буюу 98.0 хувь нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга байна. Цахим тендер шалгаруулалтын урилга өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад, 12 хувиар буюу 3581 урилгаар нэмэгдсэн нь захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, цахим системийн хэрэглээ нэмэгдсэн, худалдан авах ажиллагааны ил тод байдалд ахиц гарсныг харуулж байна. Улсын хэмжээний уг системийн зарим тоон үзүүлэлтийн үр дүнг танилцуулбал:<br><br>– 1835 захиалагч байгууллагын хэрэгжүүлэх 23653 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө цахим системд бүртгэгдэж, олон нийтэд мэдээлэгдсэн;<br><br>– тус системээр дамжин нийт 8328 тендер шалгаруулалтын үр дүн олон нийтэд мэдээлэгдсэн байна. Үүнээс: нээлтийн 3140, тендер шалгаруулалтын 4947 үр дүн гарсныг мэдээлсэн бол хянан үзсэн 259, бусад үр дүнгийн 53 төлөв гарсан дүнтэй байна;<br><br>– бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд нийт 26659 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байна;<br><br>– 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд тус системийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр нийт 712 удаагийн захиалга хийгдэж, 3.9 тэрбум төгрөгийн 32 нэр төрлийн эм борлуулагдан улсын төсөвт 165.2 сая төгрөгийн хэмнэлт гарсан;<br><br>– нийт 3079 гэрээ тус цахим системд бүртгэгдсэн байна. | | |
| 46 | 75 | **Монгол Улсын Засгийн газраас зарласан “Хариуцлагын жил”-ийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайлан**<br><br>2019-01-16, № 3<br><br>I.Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br><br>2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/101, А/102 дугаар тушаалуудаар “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, “Дуудлагын худалдааны талаар авах арга хэмжээний тухай” 2016 оны 128 дугаар тогтоол шинэчлэн боловсруулах ажлын хэсгүүдийг байгуулан ажиллуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 260, 268, 269, 271 дүгээр тогтоолуудаар баталсан. Төн Төрийн өмчийн | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | нарт даалгав: 1.Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг хуулийн дагуу төлөвлөгөө гарган, шилэн дансанд байршуулах замаар 2019 оны I улиралд багтаан олон нийтэд ил тод, шуурхай зохион байгуулах; 2.Төрийн болон нутгийн удирдлагын бүх шатны байгууллагууд баталсан дүрэм, журамдаа шинжилгээ хийж, иргэд, олон нийтээр хэлэлцүүлэн, байгууллага, иргэдэд хүнд суртал, чирэгдэл үүсгэж байгаа дүрэм, журмыг хүчингүй болгох арга хэмжээ авч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт мэдээг хагас, бүтэн жилээр ирүүлэх; 3.Төрийн байгууллагад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй төрийн албан хаагч, албан тушаалтанд хариуцлага тооцож, өргөдөл гомдол шийдвэрлэлтийн мэдээнд тусгаж байх; 4.Төрийн албан хаагч ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаар тогтоосон дэг журмыг чанд мөрдүүлэх, журмыг зөрчсөн албан хаагчтай тухай бүр холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож байх; 5.Яам, агентлагийн бодлого, шийдвэрийг бусад байгууллага болон олон нийтэд ил тод мэдээлэх, тусгай зөвшөөрөл олгох ажлыг цахимжуулах арга хэмжээ авах; 6.Төрийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийцүүлэн төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг сар бүр дүгнэж ажиллах; 7.Төрийн бүх шатны байгууллагын салбар, нэгжийн ажлын уялдаа, бүтээмжийн үнэлгээг тодорхой болгох; 8.Төрийн албан | бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/100, А/103 дугаар тушаалуудаар "Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож баталгаажуулах ажлыг зохион байгуулах журам, "Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар", "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам"-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгүүдийг байгуулан ажиллуулж байна.<br><br>3.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт Засгийн газрын "Иргэд, олон нийттэй харилцах төв"-өөр дамжуулан 2019 оны эхний хагас жилд төрийн худалдан авах ажиллагааны цахим системтэй холбоотой 3, худалдан авах ажиллагаатай холбоотой 1, орон сууц хувьчлалын талаах 1, газрын цахим хуудастай холбоотой 1, нийт 6 иргэн санал, хүсэлт, гомдол, ирүүлснийг хүлээн авч, бүртгэлд хамруулан хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллав.<br>2019 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар 102 өргөдөл, гомдлыг бичгээр хүлээн авч, байгууллагын дотоод сүлжээ www.able цахим системд бүртгэн, удирдлагын заалтын дагуу албан хаагчид хуваарилан хүргүүлснээс шийдвэрлэгдсэн 86, хяналтад 10, хугацаа хэтэрсэн, шийдвэрлэгдээгүй 5 (ЗХЗХ-1, БТУХ-3, ТӨБХХ-1) өргөдөл байна. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд 2018 оны жилийн эцэс, 2019 оны 1 дүгээр улирлын шийдвэрлэлтийн тайланг газрын цахим хуудсанд байршуулсан.<br>Мөн 2019 оны 4 дүгээр сард "Албан бичиг, өргөдөл гомдлын хугацаа хэтрэлтэд дотоод аудит хийх" тухай удирдамжийг ТӨБЗГ-ын даргаар батлуулан аудит хийж, тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын зөвлөл болон нийт албан хаагчдад танилцуулж, холбогдох хууль, журам зааврын мөрдөлтийг сайжруулж, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар" өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.<br>Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд 2018 оны жилийн эцэс, 2019 оны 1 дүгээр улирлын шийдвэрлэлтийн тайланг газрын цахим хуудсанд байршуулсан.<br><br>4."Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ыг газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, уг журмын 7.2.3-т ажлын байр, хууль, журмаар тогтоосон албан үүрэгтэй холбоотой | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | хаагчдад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулах, хууль зөрчсөн албан хаагчдад заавал хариуцлага тооцож байх; 9.Төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын ажлын үр дүнг иргэдийн сэтгэл ханамжийн үзүүлэлттэй холбон дүгнэх үнэлгээний журам тогтоох. | газар ажлын болон ажлын бус цагаар согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хориглосон заалт оруулсан. 2019 оны хагас жилийн байдлаар ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэсэн зөрчил гараагүй болно.<br><br>6.Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/, “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөө жил болон улирлаар төлөвлөж сар бүр тайлагнаж байхаар зохицуулагдсан хэдий ч гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээ, тайлан гаргах заавар, аргачлал маягтыг Засгийн газар батлахаар зохицуулагдсан бөгөөд тус аргачлал батлагдаагүй тул албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар бүр дүгнээгүй, 2019 оны 2 дугаар улирлын байдлаар дүгнэхээр бэлтгэж байна.<br><br>8. Авлигын эсрэг сургалт, соён гэгээрүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газартай хамтран баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд тусгаснаар 2019 онд нийт 13 төрлийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж, түүнд ТӨБЗГ, түүний харьяа ТӨХЭ-ийн давхардсан тоогоор 1301 албан хаагчийг хамруулахаар төлөвлөсөн. Эхний хагас жилд нийт 491 албан хаагчийг ёс зүйн болон авлигын эсрэг суурь мэдлэг олгох сургалтад хамруулсан (ТӨХЭ-ийн 57 захирал, нягтлан бодогч нарыг ёс зүйн сургалтад, Орон нутгийн өмчийн газрын 77 албан хаагч, АТГ-ын Олон нийтийн төвд төрийн өмчит 11 хуулийн этгээдийн 201 албан хаагчийг авлигын эсрэг суурь сургалтад, Орхон аймагт зохион байгуулсан сургалтад 8 хуулийн этгээдийн 156 албан хаагчийг тус тус хамруулсан).<br><br>9.Хэрэгжээгүй. | | |
| | 76 | **Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулсан дүнгийн тухай**<br><br>2019-01-16, № 3<br><br>II.Үүнтэй холбогдуулан: 1.Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хариуцлагатай, мэргэшсэн, тогтвортой төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор дараахь арга хэмжээ авч ажиллахыг | **ТӨБЗГ – ЗХЗХ**<br><br>1.1.Байгууллага, нэгжийн чиг үүргийн шинжилгээг хийх үүрэг бүхий Ажлын хэсгийг ТӨБЗГ-ын даргын 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/86 дугаар дугаар тушаалаар байгуулан ажиллуулж байна. Ажлын хэсгээс зохион байгуулсны дагуу нэгжүүдийн чиг үүргийн шинжилгээг хэлтэс, алба бүр хийсэн. Ажлын хэсгээс уг шинжилгээг боловсронгуй болгон иж бүрэн шинжилгээ хийхээр чиг үүргийн давхардал, хийдлийг судлан, дүгнэлт гаргасны дүнд байгууллага, албан хаагчдын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн чиг үүргийн дахин хуваарилалтыг хийж, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахаар бэлтгэж байна. Ажлын хэсгээс | “Хэрэгжих шатанд – 70% | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов: 1.1.төрийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, хийдлийг арилгах, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор төрийн бүх шатны байгууллага Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу чиг үүргийн шинжилгээ хийж, чиг үүрэг дахин хуваарилах саналаа 2019 оны 12 дугаар сард багтаан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх; 1.2.төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилох, төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын сул орон тоог нөхөхдөө чадахуйн (мерит) болон шатлан дэвшүүлэх зарчмыг үндсэн шалгуур болгон Төрийн албаны тухай хуулийг чанд баримтлах; 1.3.төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан тушаалтнуудын судалгаанд үндэслэн Төрийн албаны хуульд заасан шаардлага хангаж байгаа албан тушаалтнуудыг зохих журмын дагуу томилох, шаардлага хангахгүй байгаа албан тушаалтнуудыг үүрэгт ажлаас чөлөөлж, дүнг 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлэх; 1.4.төрийн захиргааны албан тушаалын байнгын ажлын байранд гэрээт ажилтан ажиллуулж хууль тогтоомж зөрчдөг үйлдлийг таслан зогсоох, ийм гэрээт ажилтны гэрээг цуцалж, уг орон тоог хуульд заасан журмын дагуу нөхөх; 1.5.төрийн захиргааны байгууллагын ашиглаж байгаа компьютер, техник хэрэгслийн элэгдлийг тооцон шинэчлэх | байгууллагын чиг үүргийн шинжилгээг Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу урьдчилсан байдлаар хийсэн бөгөөд чиг үүрэг дахин хуваарилах саналаа ЗГХЭГ-т хүргүүлэхээр ажиллаж байна.<br><br>1.2.2019 оны хагас жилийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас төрийн захиргааны 5 хаагчийг чөлөөлсөн. Төрийн захиргааны 5 сул орон тоонд эрүүл мэндийн шалтгааны улмаас чөлөөтэй байсан 1 албан хаагчийг эргүүлэн, 2 албан хаагчийг байгууллага дотроосоо, 1 албан хаагчийг удирдах албан тушаалтны нөөцөөс нөхөн томилж, 1 албан тушаалын сул орон тоонд төрийн албаны нөөцөөс нөхөн томилохоор хүлээж байна.<br><br>1.3.2019 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар томилогдсон 5 удирдах албан тушаалтан ажиллаж байгаа ба тэдгээрийн дотор түр орлон гүйцэтгэгч байхгүй бөгөөд төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн болно.<br><br>1.4.2019 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалд гэрээт ажилтан ажиллуулаагүй болно.<br><br>1.5.Газрын өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй, үлдэгдэл өртөггүй 56,433.930 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 160 ширхэг тавилга, эд хогшил, 27,557.312 мянган төгрөгийн балансын үнэ бүхий 15 ширхэг компьютер, техник хэрэгслийг холбогдох заавар, журмын дагуу акталж, данснаас хасахаар шийдвэрлэсэн. Аклагдсан 15 ширхэг компьютер болон 2018 онд акталж данснаас хасагдсан 39 ширхэг, нийт 54 ширхэг актлагдсан компьютерийг албан хаагчид ашиглаж байсан бөгөөд 2019 оны 06 дугаар сард шинээр 30 ширхэг суурин компьютер, 8 ширхэг зөөврийн компьютер, 13 ширхэг 3 үйлдэлт принтерийг шинээр худалдан авсан. Цаашид шаардлагатай 24 ширхэг суурин компьютерийг 2020 оны төсөвт суулгахаар бэлтгэж байна.<br><br>1.6.Хэрэгжээгүй.<br><br>1.7.Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнийг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академийн мэргэшүүлэх сургалтуудад хамруулан тогтвортой ажиллуулж байна.<br><br>1.8. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд “Төрийн өмчийн бодлого, | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | арга хэмжээг батлагдсан төсвийн багцдаа багтаан үе шаттайгаар хэрэгжүүлэх; 1.6.төрийн байгууллагын үйл ажиллагаанд ажлын байрны зураг авалт хийсний үндсэн дээр боломжит үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах; 1.7.төрийн албаны хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнийг мэргэшүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах; 1.8.төрийн бүх шатны албан хаагчийг хамруулах сургалтын хуваарийг жил бүрийн 1 дүгээр сард багтаан төлөвлөх, албан хаагчдыг сургалтад хамруулах, хэрэгцээ шаардлага, үр дүн нь тодорхой бус сургалтад оролцуулахаас татгалзах; 1.9.Төрийн албаны тухай хууль, холбогдох журамд заасны дагуу төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээг бодитой, үнэн зөв үнэлэх, үнэлгээний дагуу цалин урамшуулал, хариуцлагын асуудлыг хууль, дүрэм, журамд нийцүүлэн хэрэгжүүлж байх; 1.10.төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулах, хагас, бүтэн жилээр явцын хяналт-шинжилгээ хийж үр дүнг албан хаагчдад тогтмол мэдээлж байх; 1.11.төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэн байгууллага, нутаг дэвсгэртээ хууль хэлбэрэлтгүй хэрэгждэг соёлыг тогтоож иргэдийн итгэлийг хүлээсэн, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр өөрийн эрх хэмжээний хүрээнд үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулж хэвшүүлэх. | зохицуулалтын газрын албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөө”-ний төслийг хэлтэс, албаны саналыг тусган 22 сургалт зохион байгуулахаар боловсруулж, газрын даргын А/48 дугаар тушаалаар албажуулан able.mn дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад танилцуулсан. Тус төлөвлөгөөний дагуу “Мэдлэгийн менежментийн хүрээлэн”-гийн захирал П.Мөнхтогтоор “Харилцааны урлаг”, “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн мэдээллийн төвийн албаны дарга Б.Батбаяр, мэргэжилтэн Г.Бямбацэрэн нараар “Иргэн бүрд олгосон 1072 хувьцаа”, Архивын ерөнхий газартай хамтран “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх”, Хууль зүй дотоод хэргийн яамтай хамтран “Захиргааны хэм хэмжээний акт” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж нийт албан хаагчдын хамруулсан. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Архивын ерөнхий газар, Удирдлагын академи зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан 14 удаагийн сургалтад давхардсан тоогоор 50 гаруй албан хаагчийг хамруулж мэдлэг, мэргэшлийг дээшлүүлсэн.<br><br>1.9.“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ыг газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, уг журмаар зохицуулсан боловч, гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлах, үнэлэх аргачлал, загвар Засгийн газраас батлагдаагүй, урамшууллын асуудал 2019 оны төсөв суугаагүй зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй байна.<br><br>1.10.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулж газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба 2019 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг гарган явцын хяналт-шинжилгээ хийхээр бэлтгэж байна.<br><br>1.11.Албан хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлэх, иргэдийн итгэлийг хүлээсэн, ил тод, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-т өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацааг багасган, асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэж байхаар төсөл боловсруулан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Даргын зөвлөл”-д танилцуулсан бөгөөд албажуулахаар бэлтгэж байна. | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 47 | 77 | **“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх тухай**<br><br>2019-01-30, № 6<br><br>XXII.5. Үүнтэй холбогдуулан “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг энэ оны эхний улиралд багтаан холбогдох хууль тогтоомжийн дагуу судалж шийдвэрлэхийг тус компанийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгч Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br><br>Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 16 дугаар тэмдэглэлийг үндэслэн “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 20 дугаар тогтоолоор ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | Бүрэн хэрэгжсэн гэж үзэж хяналтаас хасах саналтай. |
| 48 | 78 | **Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2018 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай тайлан, үнэлгээний дүнгийн тухай**<br><br>2019-03-21, № 11<br><br>23.12.2. Худалдан авах ажиллагааны цахим системийн үйл ажиллагааг сайжруулах, статистик тоон мэдээллийн давхардалгүй, үнэн зөв байдлыг хангах, Ерөнхий гэрээ байгуулах ажлыг эхлүүлэхтэй холбоотойгоор цахим дэлгүүрийн хэвийн ажиллагааг хангаж, холбогдох гарын авлагыг боловсруулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгав. | **ТӨБЗГ – МТА**<br><br>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.pcsp.gov.mn -ийн ашиглалтыг нэмэгдүүлэх, цахим худалдан авах ажиллагааны чадавхийг сайжруулах зорилгоор цахим худалдан авах ажиллагааны системийн сургалтыг худалдан авах ажиллагааны захиалагч байгууллага, тендерт оролцогч аж ахуйн нэгжийн төлөөлөлд зохион байгуулж, 456 албан хаагч, иргэнийг оролцуулав.<br><br>2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, улсын дүнгээр нийт 10,000 тендер шалгаруулалтын урилга зарлагдсан дүнтэй байна. Үүнээс 9799 буюу 98.0 хувь нь “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга байна. Цахим тендер шалгаруулалтын урилга өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад, 12 хувиар буюу 3581 урилгаар нэмэгдсэн нь захиалагч байгууллагууд худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, цахим системийн хэрэглээ нэмэгдсэн, худалдан авах ажиллагааны ил тод байдалд ахиц гарсныг харуулж байна. Улсын хэмжээний уг системийн зарим тоон үзүүлэлтийн үр дүнг танилцуулбал:<br><br>– 1835 захиалагч байгууллагын хэрэгжүүлэх 23653 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөө цахим системд бүртгэгдэж, олон нийтэд мэдээлэгдсэн;<br><br>– тус системээр дамжин нийт 8328 тендер шалгаруулалтын үр дүн | “Бүрэн хэрэгжсэн” – 100% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | олон нийтэд мэдээлэгдсэн байна. Үүнээс: нээлтийн 3140, тендер шалгаруулалтын 4947 үр дүн гарсныг мэдээлсэн бол хянан үзсэн 259, бусад үр дүнгийн 53 төлөв гарсан дүнтэй байна;<br>– бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд нийт 26659 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байна;<br>– 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд тус системийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр нийт 712 удаагийн захиалга хийгдэж, 3.9 тэрбум төгрөгийн 32 нэр төрлийн эм борлуулагдан улсын төсөвт 165.2 сая төгрөгийн хэмнэлт гарсан;<br>– нийт 3079 гэрээ тус цахим системд бүртгэгдсэн байна. | | |
| 49 | 79 | **Албан татварын төлөх хугацааг сунгах тухай**<br>2019-04-10, №16<br>ҮIII.2.Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрсний хэрэглээг хориглох арга хэмжээ авсантай холбогдуулан “Цогцолборыг шилжүүлэх, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх тухай” Засгийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолоор Батлан хамгаалах яамны мэдэлд шилжүүлсэн барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор (UBM)-ыг сайжруулсан түлшний үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүнийг нөөцлөх барилга байгууламж барих болон бусад арилжааны зорилгоор ашиглахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгав. | **ТӨБЗГ – БТУХ**<br>Шинээр бүртгэгдсэн шийдвэр тул зохион байгуулалтын арга хэмжээ авч эхэлж байгаа. | Хугацаа болоогүй – Үнэлэх боломжгүй | |
| | 80 | **Албан татварын төлөх хугацааг сунгах тухай**<br>2019-04-10, №16<br>ҮIII.3.Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор (UBM)-ын ашиглалтаас олох орлогыг Хөгжлийн | **ТӨБЗГ – БТУХ**<br>Шинээр бүртгэгдсэн шийдвэр тул зохион байгуулалтын арга хэмжээ авч эхэлж байгаа. | Хугацаа болоогүй – Үнэлэх боломжгүй | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | банкны зээл, зээлийн хүүг эргэн төлөхөд зарцуулахыг Батлан хамгаалахын сайд Н.Энхболд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Ганбат)-т даалгав. | | | |
| | | **Тэмдэглэл: 9 шийдвэрийн 14 заалт** | **100% - 8 заалт; 70% - 2 заалт; 30% - 1 заалт; 0% - 1 заалт; ХБ/ҮБ – 2 заалт; Хэрэгжилтийн хувь – 80.8%** | | |
| **Долоо. Засгийн газрын албан даалгавар** | | | | | |
| 50 | 81 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>1. Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагын дарга, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад: 1.1. Иргэндээ ээлтэй хуулийн засаглалыг бэхжүүлэх: Төрийн бүх шатны байгууллагын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчмыг баримтлан ажиллахыг эрмэлзэж, энэ талаар соён гэгээрүүлэх, сургалтын ажлыг зохион байгуулан ажилласан. Мөн албан хаагчдын шударга ёс, хууль дээдлэх ёсны талаар мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор Авлигатай тэмцэх газрын олон нийтийн төвд зохион байгуулагдаж буй төлөвлөгөөт 13 удаагийн сургалтад 491 албан хаагч хамрагдан, мэдлэг мэргэшлээ дээшлүүлсэн байна. 2019 оны эхний 6 сарын байдлаар төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчиж сахилгын шийтгэл оногдуулсан тохиолдол гараагүй болно. | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |
| | 82 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>1.2. Авлигын хяналтыг сайжруулах: Төрийн албыг хувийн ашиг сонирхлын хэрэгсэл болгох гэсэн оролдлогыг тухай бүр нь таслан зогсоож, авлига, хээл хахууль, хүнд суртал, шударга бус байдалтай шат шатандаа тууштай тэмцэх; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих чиглэлээр Авлигатай тэмцэх газраас 3 гишүүн бүхий олон нийтийн дэд зөвлөлийг АТГ, ТӨБЗГ, зөвлөлийн гишүүдийн гурвалсан гэрээний дагуу тус байгууллагад ажиллуулж байна. Албан үүргээ гүйцэтгэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд хуульд заасан мэдэгдэл, тайлбарыг гарган шийдвэрлүүлж ажиллах талаар ТӨБЗГ-ын албан хаагчид болон харьяа төрийн өмчит хуулийн этгээдийг мэдээлэл, зөвлөмж, чиглэлээр ханган ажиллав. ТӨБЗГ-ын албан хаагчид худалдан авах ажиллагаа зохион байгуулах болон бусад асуудлаар шийдвэр гаргах үедээ ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай нийт 140 мэдэгдэл, тайлбар гаргаж, бүртгүүлсэн байна.<br>Авлигын эсрэг сургалт, соён гэгээрүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг | “Хэрэгжих шатанд” – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Авлигатай тэмцэх газартай хамтран баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд тусгаснаар 2019 онд нийт 13 төрлийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж, түүнд ТӨБЗГ, түүний харьяа ТӨХЭ-ийн давхардсан тоогоор 1301 албан хаагчийг хамруулахаар төлөвлөсөн. Эхний хагас жилд нийт 491 албан хаагчийг ёс зүйн болон авлигын эсрэг суурь мэдлэг олгох сургалтад хамруулсан (ТӨХЭ-ийн 57 захирал, нягтлан бодогч нарыг ёс зүйн сургалтад, Орон нутгийн өмчийн газрын 77 албан хаагч, АТГ-ын Олон нийтийн төвд төрийн өмчит 11 хуулийн этгээдийн 201 албан хаагчийг авлигын эсрэг суурь сургалтад, Орхон аймагт зохион байгуулсан сургалтад 8 хуулийн этгээдийн 156 албан хаагчийг тус тус хамруулсан).<br><br>Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр ТӨБЗГ-ын даргын 2019 оны 01 тоот албан даалгаврыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 72 компани, үйлдвэрийн газарт хүргүүлсний дагуу 1 дүгээр улирлын тайланг нэгтгэв. 15 заалт бүхий уг албан даалгаврын хэрэгжилтийг улирал бүр тайлагнаж, албан хаагчдаар авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах, хуульд заасан хориглолт хязгаарлалтыг судлуулан хэрэгжүүлж хэвших талаар хугацаатай үүрэг өгсөн. Албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд албан хаагчдаар амлалт, баталгаа гаргуулах ажлыг нийт 38 компани, үйлдвэрийн газар өөр өөрийн арга хэлбэрээр зохион байгуулсан байна. Тэдгээрийн удирдах болон эрх бүхий нийт 1017 албан тушаалтан авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахаа амлалт болгон баталгаа гаргасан байна. | | |
| | 83 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br><br>2017-10-26, № 01<br><br>1.3. Иргэдээ сонсож, төрийн албаны хариуцлагыг өндөржүүлэх: “Засгийн газрын иргэд олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг шийдвэрлэн дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд тухай бүр хариуцлага тооцож ажиллах; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br><br>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-өөр дамжуулан 2019 оны эхний хагас жилд төрийн худалдан авах ажиллагааны цахим системтэй холбоотой 3, худалдан авах ажиллагаатай холбоотой 1, орон сууц хувьчлалын талаах 1, газрын цахим хуудастай холбоотой 1, нийт 6 иргэн санал, хүсэлт, гомдол, ирүүлснийг хүлээн авч, бүртгэлд хамруулан, удирдлагын заалтын дагуу холбогдох албан хаагчид шилжүүлэн, шийдвэрлэлтэд нь бүртгэлээр хяналт тавин ажиллав. Дээрх өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцсон тохиолдол гараагүй байна.<br><br>ТӨБЗГ-т 135 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эхлүүлээд байгаа бөгөөд ШӨХТГазарт тендерийн баримт бичигтэй холбоотой 9 гомдол гарсанаас 1 гомдол нь хянагдаж байгаа, 2 гомдол нь тендерийн баримт бичигт өөрчлөлт оруулах, 6 гомдол нь тендерийн | “Бүрэн хэрэгжсэн” – 100 % | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | баримт бичигт өөрчлөлт оруулах шаардлагагүй, өрсөлдөөн хязгаарлаагүй гэж хянагдсан байна. Тендерт оролцогчоос Сангийн яаманд 8 гомдол гаргаснаас 3 гомдол нь дахин үнэлгээ хийх, 2 гомдол хянагдаж байгаа, 3 гомдол нь захиалагчийн шийдвэр үндэслэлтэй гэж хянгдсан байна. 2019 онд худалдан авах ажиллагааны чиглэлээр Шүүхэд гомдол гаргасан тохиолдол байхгүй байна. | | |
| | 84 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>1.4. Төрийн албаны үр ашгийг сайжруулах: Ажилтан, албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахих; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>ТӨБЗГ-ын албан хаагчдын цаг ашиглалт, бүртгэлийн байдалд дотоод сүлжээний www.able.mn цахим систем, хурууны хээ уншиж төхөөрөмжийг ашиглан хэлтэс, албаны удирдлагууд тухай бүр хяналт тавин ажиллаж байна. Цаг бүртгэлийн мэдээг 7 хоног бүр газрын удирдлагад танилцуулж, газрын албан хаагчийн ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор 7 хоногт нэг удаа ажлын байран дахь гэнэтийн шалгалт зэргийг хийж хэвшсэн. Тайлант хугацаанд ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй, удирдлагын зөвшөөрөлгүйгээр ажлын байр орхин явсан зөрчил гараагүй байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| | 85 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>1.5. Бодлогын тогтвортой байдлыг хангах: Төрийн бодлогын залгамж чанар, тогтвортой байдлыг хангаж, төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Албан хаагчдыг тогтвортой суурьшилтай ажиллуулах зорилгоор ТӨБЗГ-ын даргын 2017 оны А/108 дугаар тушаалаар "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр", А/106 дугаар тушаалаар балагдсан "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид тусламж, тэтгэмж, нөхөн олговор олгох журам"-ыг тус тус мөрдөн ажиллаж байна.<br>"Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөө"-ний төслийг хэлтэс, албадын саналыг тусган 22 сургалт зохион байгуулахаар боловсруулж, газрын даргын А/48 дугаар тушаалаар албажуулан able.mn дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад танилцуулсан. Тус төлөвлөгөөний дагуу "Мэдлэгийн менежментийн хүрээлэн"-гийн захирал П.Мөнхтогтоор "Харилцааны урлаг", "Эрдэнэс тавантолгой" ХК-ийн мэдээллийн төвийн албаны дарга Б.Батбаяр, мэргэжилтэн Г.Бямбацэрэн нараар "Иргэн бүрд олгосон 1072 хувьцаа", Архивын ерөнхий газартай хамтран "Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх", Хууль зүй дотоод хэргийн яамтай хамтран "Захиргааны хэм хэмжээний акт" сэдэвт сургалтуудыг зохион байгуулж нийт албан хаагчдын хамруулсан. Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Архивын ерөнхий газар, Удирдлагын академи зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан 14 удаагийн сургалтад давхардсан тоогоор 50 гаруй албан хаагчийг хамруулж | "Хэрэгжих шатанд" – 70% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | мэдлэг, мэргэшлийг дээшлүүлсэн. | | |
| | 86 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>2.4. Хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан, ажлаа цалгардуулсан албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу тухай бүр нь хариуцлага тооцож, зохих байгууллага, албан тушаалтанд мэдээлж байх; | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>Төрийн албаны тухай хууль болон "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг зөрчсөн тохиолдол гараагүй болно. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| | 87 | **Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай**<br>2017-10-26, № 01<br>3. Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын чанар, үр дүнг дээшлүүлж, төсвийн үргүй зардлыг багасган хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулж, хэмнэлтийн горимыг чанд сахин ажиллахыг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгаж байна. | **ТӨБЗГ – ЗХЗХ, бүх хэлтэс, алба**<br>2019 онд ТӨБЗГ-ын үйл ажиллагааны зардалд 1,505,074.60 мянган төгрөгийн төсөв батлагдсан бөгөөд 2019 эхний хагас жилд 682,158.78 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч, 2019 оны сүүлийн хагас жилд 822,915.87 мянган төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.<br>Засгийн газрын 2018 оны 388 болон 2019 оны 46 дугаар тогтоолуудаар батлагдсан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 169 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2019 онд зохион байгуулна. Эдгээрээс эхний хагас жилийн байдлаар 135 (79.8 %) төсөл, арга хэмжээний зураг, төсөл шаардлагатай материалыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсний дагуу үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. 28 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, улсын төсөвт 4.1 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргаад байна. | "Бүрэн хэрэгжсэн" – 100% | |
| | | **Албан даалгавар:**<br>**1 шийдвэрийн 7 заалт.** | **100% - 5 заалт; 70% - 2 заалт; Хэрэгжилтийн хувь - 91.4%.** | | |

**(Нийт 7 төрлийн 50 шийдвэрийн 87 заалтын хэрэгжилтийг тайлагнав)**

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ДҮН (нэр төрлөөр)
(2019 оны эхний хагас жилийн дүн)

| Д/д | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн нэр төрөл | Шийд-вэрийн тоо | Хэрэг-жилтийг тооцсон заалтын тоо | Үүнээс: | | | | | Хэрэгжилтийн явц (хувиар) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Бүрэн хэрэгжсэн (100 %) | Хэрэгжих шатанд (70 %) | Хэрэгжилт хангалтгүй (30 %) | Хэрэгжээгүй (0 %) | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй (ХБ.) | |
| 1 | УИХ-ын тогтоол | 2 | **2** | | 1 | | | 1 | **70.0** |
| 2 | Ерөнхийлөгчийн зарлиг | 1 | **2** | 2 | | | | | **100.0** |
| 3 | Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж | 1 | **1** | 1 | | | | | **100.0** |
| 4 | Засгийн газрын тогтоол | 33 | **58** | 30 | 17 | 3 | | 8 | **85.6** |
| 5 | Ерөнхий сайдын захирамж | 3 | **3** | | 1 | | | 2 | **70.0** |
| 6 | Засгийн газрын хуралдааны тэмдэглэл | 9 | **14** | 8 | 2 | 1 | 1 | 2 | **80.8** |
| 7 | Засгийн газрын албан даалгавар | 1 | **7** | 5 | 2 | | | | **91.4** |
| **Хэрэгжилтийн дүн (шийдвэр, заалтын тоо)** | | **50** | **87** | **46** | **23** | **4** | **1** | **13** | **85.4** |

ТАНИЛЦСАН:
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДЭД ДАРГА А.ДАГВАДОРЖ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА А.АРИУНБОЛД

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН Х.ЭНХЧИМЭГ